СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01

# Э-ТРАНС ЛОЖИСТИКС

Ачаа шилжүүлэн ачих терминал

# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

## Олон нийтэд санал болгох хувьцааны мэдээлэл

| | |
|---|---|
| Хувьцааны тоо: | 7,700,000 |
| Хувьцааны нэрлэсэн үнэ: | 100 |
| Зах зээлд санал болгох доод үнэ: | 120 |
| Татан төвлөрүүлэх хөрөнгө: | 924,000,000 |
| Анхдагч зах зээлд байршуулах арга: | Захиалгын бүртгэлийн арга |

## Онцлох мэдээлэл:

Үнэт цаас гаргагч нь Монгол улсыг БНХАУ-тай холбосон хамгийн том боомт болох Замын-Үүд боомтод байрлан БНХАУ-ын Эрээн боомтоор дамжин ачааны машинаар тээвэрлэгдэн ирж буй импортын барааг вагонд, вагоноор ирж буй экспортын барааг ачааны машинд шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагаа эрхэлдэг.

Компани цаашдын үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг компанийн 16,67% болох 7,700,000 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагч нь Монгол улсын "Компанийн тухай хууль", "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журмуудын дагуу дүрмийн санг нэмэгдүүлж байгаа болно. Шинээр гаргаж буй үнэт цаасыг анхдагч зах зээлд захиалгын бүртгэлийн аргаар олон нийтэд байршуулна.

Анхдагч зах зээлд байршуулах хугацаанд татан төвлөрүүлэх хөрөнгийг бүрдүүлж чадаагүй тохиолдолд анхдагч зах зээлийн арилжаа амжилтгүй болсонд тооцон хөрөнгө оруулагчдын дансанд тусгаарласан хөрөнгийг тусгаарлалтаас чөлөөлнө.



АНДЕРРАЙТЕР

Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн
**"БИДИСЕК" ХК**
Андеррайтер, Брокер,
Хөрөнгө Оруулалтын Зөвлөх
www.bdsec.mn

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Залуучуудын өргөн чөлөө 27/1, "БиДиСЕК" ХК-ийн төв оффис

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, ... "БИДИСЕК" ...
ТТА4467 ... 2052...

СЗХ
2012 он.01 сар.18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДИЙН АНХААРАЛД

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН "КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ", "ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ" БОЛОН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ДАГУУ ӨӨРИЙН ДҮРМИЙН САНГ НЭМЭГДҮҮЛЭН ОЛОН НИЙТЭД АНХ УДАА ХУВЬЦААГАА САНАЛ БОЛГОН ГАРГАЖ БАЙГАА БОЛНО.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.1-Д ЗААСНЫ ДАГУУ ОЛОН НИЙТЭД САНАЛ БУЙ ГАРГАЖ БУЙ ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны (хувьцааны) танилцуулгад хөрөнгө оруулагч танд хувьцаа худалдан авах шийдвэр гаргахад туслах, шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Танилцуулгад хөрөнгө оруулагч танд шаардлагатай мэдээллийг бүрэн оруулаагүй байж болох ба лавлах тодруулах зүйлийг Үнэт цаас гаргагч компани болон Андеррайтерын "БиДиСЕК" ХК-д хандаж авна уу.

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№



## ХУРААНГУЙ

### ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

**Компанийн оноосон нэр:** Э-Транс Ложистикс ХК

**Оршин байх албан ёсны хаяг:** Монгол улс, Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг

**Үйл ажиллагааны чиглэл:** Хятад улсын Эрээн боомтоор дамжин ачааны машинаар тээвэрлэгдэн ирж буй импортын барааг вагонд, вагоноор ирж буй экспортын барааг ачааны машинд шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагаа явуулдаг.

**Байршил:** Ачаа шилжүүлэн ачих терминал нь Монгол улсыг Хятадтай холбосон хамгийн том боомт болох Замын-Үүд суманд хилийн хаалганаас 100м-ийн зайд байрладаг.

*Байршлын давуу тал:*

- Ази Европыг холбох хамгийн дөт зам

  /Монголоор дайруулан Европоос Зүүн Ази хүртэл тээвэрлэхэд бусад замуудаас 1135-1600 км дөт/

- МУ-ын далайд хүрэх хамгийн дөт зам
- Худалдааны хамгийн том боомт
- Замын-Үүд эдийн засгийн чөлөөт худалдааны бүс

**Компанийн үүсгэн байгуулагчидийн хувьцаа эзэмшил:**

| № | *Үүсгэн байгуулагчид* | *Үйл ажиллагааны чиглэл, байршил* | *Эзэмшиж буй хувь* |
|---|---|---|---|
| 1 | Э-Транс ХХК | Ачаа тээврийн компани, Монгол | 60,00% |
| 2 | Монголиан Транспортэйшн Холдинг ХХК | Хөрөнгө оруулалтын сан, Люксембургын вант улс | 34.28% |
| 3 | БиДиПиИЭф ХХК | Хөрөнгө оруулалтын сан, АНУ-д бүртгэлтэй | 3.90% |
| 4 | Х.Батхишиг | "BLJ" ХХК-ийн захирал | 1.82% |
| | ***Нийт гаргасан хувьцаа*** | | ***100%*** |

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## ХУРААНГУЙ

### ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| **Үнэт цаасны нэр:** | Э-Транс Ложистикс |
| **Хувьцааны төрөл:** | Энгийн |
| **Үнэт цаасны хэлбэр:** | Биет бус |
| **Үнэт цаасны нэрлэсэн үнэ:** | 100 |
| **Үнэт цаасны нийт тоо ширхэг:** | 46,200,000 |
| **Хөрвөх үнэт цаасны тоо ширхэг:** | 38,500,000 |
| **Нийтэд санал болгох хувь:** | 16,67% |
| **Нийтэд санал болгох үнэт цаасны тоо ширхэг:** | 7,700,000 |
| **Анхдагч зах зээлд байршуулах:** | Нийт хувьцааны 16,6% буюу 7,700,000 ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар анхдагч зах зээлд олон нийтэд байршуулна. |
| **Санал болгох үнэ:** | Үнэт цаасыг олон нийтэд санал болгох доод үнэ 120 төгрөг байна. |

**Хаалттай компанийн хувь нийлүүлэгчдийн хөрвүүлэн эзэмших хувьцааны ширхэг:**

| *№* | *Хувьцаа эзэмшигч* | *Тоо ширхэг* | *Эзэмших хувь /%/* |
|---|---|---|---|
| 1 | “Э-Транс” ХХК | 23,100,000 | 50.00% |
| 2 | Би Ди Пи И Эф ХХК | 1,500,000 | 3.25% |
| 3 | Х.Батхишиг | 700,000 | 1.52% |
| 4 | Монголиан транспортэйшн холдинг ХХК | 13,200,000 | 28.57% |
| | ***Нийт хөрвүүлэн эзэмших хувь*** | ***38,500,000*** | ***83.33%*** |
| 5 | Олон нийтэд санал болгох | 7,700,000 | 16.67% |
| | ***Нийт*** | ***46,200,000*** | ***100.00%*** |

**Үнэт цаасны борлуулалтаас татан төвлөрүүлэх хөрөнгө**

| | |
|---|---|
| Санал болгох хувьцааны ширхэг | 7,700,000 |
| Нийтэд санал болгох доод үнэ | 120 |
| Татан төвлөрүүлэх доод хэмжээ | 924,000,000 |

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## ХУРААНГУЙ

### Хөрөнгө оруулалтын зарцуулалт

| | *Үйл ажиллагаа* | *Үнийн дүн* |
|---|---|---|
| 1 | Нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга | 434,050,000 |
| 2 | Автопогрузчик 3тн | 87,500,000 |
| 3 | Боодлын ачаа шилжүүлэн ачих туузан дамжуурга. | 156,250,000 |
| 4 | Вагоноос авто машинд нунтаг ачааг шилжүүлэн ачих туузан дамжуурга | 200,000,000 |
| 5 | Хөрөнгө оруулалт татахтай холбогдсон зардал | 46,200,000 |
| | ***Нийт хөрөнгө оруулалт*** | ***924,000,000*** |

### Төлөвлөж буй хөрөнгө оруулалтын өгөөж

мян.төг

| *ҮЗҮҮЛЭЛТ* | *2012* | *2013* | *2014* | *2015* | *2016* |
|---|---|---|---|---|---|
| Татварын дараах цэвэр ашиг | 145,954,300 | 307,800,100 | 459,993,200 | 614,168,700 | 776,304,800 |
| Хувьцааны ширхэг | 46,200,000 | 46,200,000 | 46,200,000 | 46,200,000 | 46,200,000 |
| Үнэ | 120 | 120 | 120 | 120 | 120 |
| EPS | 3.2 | 6.7 | 10 | 13.3 | 16.8 |
| P/E | 38 | 18 | 12.1 | 9 | 7.1 |
| ROE | 3.06% | 6.10% | 8.45% | 10.30% | 11.73% |
| ROA | 3.06% | 6.09% | 8.43% | 10.26% | 11.69% |

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



| | | 1 дахь долоо хоног | | | | | 2 дахь долоо хоног | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 1 | 2 | 3 | 4 | 5 | |
| **СЗХ-ны тогтоол, МХБ-ын бүртгэл** | СЗХ-ны тогтоол гарснаар нийтэд санал болгох нөхцөл бүрдэх | | | | | | | | | | | |
| **Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах** | Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, брокерын компаниудын цахим хуудас, и-мэйл зэргээр танилцуулга хийх | | | | | | | | | | | |
| **Захиалга авах, хаах** | | | | | | | | БДК-иудаар дамжуулан ажлын 2 өдрийн хугацаанд захиалга бүртгэх ба захиалгыг сүүлийн ажлын өдрийн арилжааны цаг дуусахад хаана. | | | | |
| **Захиалга дүгнэх, үнэ тогтоох** | | | | | | | | | Нийт захиалгыг хүлээн авч, анхдагч зах зээлд худалдах, үнийг зах зээлийн эрэлтэнд тулгуурлан тогтооно. | | | |
| **Арилжаалах зөвшөөрөл авах** | | | | | | | | | | Анхдагч зах зээлийн арилжаа хийх зөвшөөрөл Хорооноос авна. | | |
| **Анхдагч зах зээлийн арилжаа** | | | | | | | | | | Анхдагч зах зээлийн ажиллагааг зохион байгуулна. | | |
| **Тайлан гаргаж СЗХ-нд өгөх** | | | | | | | | | | | Үнэт цаасны арилжааны тайланг СЗХ-нд өгнө. | |
| **Хоёрдогч зах зээлийн арилжаа** | | | | | | | | | | | СЗХ-ны зөвшөөрлөөр хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. | |
| **ХЭХ болох** | | | | | | | | | | ХЭХ хуралдуулах тухай ТУЗ-ын шийдвэр гарах ба ХЭХ зарлах тухай мэдэгдлийг СЗХ, МХБ-д хүргэнэ. | | Бүртгэх өдрөөс хойш 45-аас доошгүй хоногийн дараа хуралдана |

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар ........ 8

Үнэт цаасны танилцуулга гаргахад оролцсон байгууллагуудын мэдээлэл ........ 10

Компанийн шийдвэр гаргалтанд оролцсон эрх бүхий этгээдүүдийн мэдээлэл ........ 11

НЭГ. КОМПАНИЙН ТУХАЙ ........ 12

1.1 Үнэт цаас гаргагч компанийн хаяг ........ 12

1.2 Үнэт цаас гаргагч компанийн бүртгэлийн тухай товч мэдээлэл ........ 12

1.3 Үнэт цаас гаргагч компанийн түүх ........ 12

1.4 Үнэт цаас гаргагч компанийн байршил ........ 20

1.5 Зах зээлийн судалгаа ........ 21

1.6 Үнэт цаас гаргагч компанийн бүтэц, зохион байгуулалт ........ 28

1.7 Үнэт цаас гаргагч компани, толгой компани, хяналтын багц эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн талаарх мэдээлэл ........ 30

1.8 Эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл ........ 32

1.9 Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн талаарх мэдээлэл ........ 33

1.10 Бусадтай байгуулсан сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл ........ 35

1.11 Компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт ........ 36

1.12 Үнэт цаас гаргагч компанийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний дүгнэлт 38

1.13 Үнэт цаас гарган санхүүжүүлж үйл ажиллагаа хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл ........ 40

ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ........ 44

2.1. Үнэт цаасны танилцуулга ........ 44

2.2. Нэмж үнэт цаас гаргах тухай шийдвэр ........ 44

2.3. Үнэт цаас эзэмшигчийн эрх ........ 45

2.4. Үнэт цаасыг зах зээлд байршуулах график: ........ 47

2.5. Захиалгын бүртгэлийн аргаар анхдагч зах зээлд байршуулах тухай ........ 48

2.6. Үнэт цаас гаргах замаар хуримтлуулах хөрөнгийг зарцуулах төслийн товч танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо ........ 53

2.7. Хөрөнгө оруулалтын өгөөж ........ 61

ЭРСДЛИЙН ШИНЖИЛГЭЭ ........ 62

АНДЕРРАЙТЕР ........ 67

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## ГРАФИКУУД

*График 1 Гадаад худалдааны өсөлт* ....21
*График 2 Авто зам, төмөр замын тээвэр* ....23
*График 3Төмөр замын тээвэр* ....23
*График 4 Хувьцаа эзэмшигчдийн бүтэц* ....28
*График 5 Санхүүжилтийн хэлбэр, IPO зарцуулалт* ....53

## ЗУРАГНУУД

*Зураг 1 Хяналтын камерын байршил* .... 14
*Зураг 2 Авто машин байрлуулах төлөвлөгөө* .... 15
*Зураг 3 Хяналтын камер* .... 16
*Зураг 4 Зөөврийн авто пүү* .... 16
*Зураг 5 Терминалын байршил* .... 20
*Зураг 6 Компанийн бүтэц зохион байгуулалт* .... 28
*Зураг 7 Анхдагч зах зээлд байршуулах график* .... 47
*Зураг 8 Нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга* .... 55

## ХҮСНЭГТҮҮД

*Хүснэгт 1 Шийдвэр гаргалтанд оролцсон эрх бүхий этгээдүүдийн мэдээлэл* .... 11
*Хүснэгт 3 Гадаад худалдааны эргэлт* .... 21
*Хүснэгт 4 Монгол улсын бараа тээвэр* .... 22
*Хүснэгт 5 Өрсөлдөгчийн судалгаа* .... 26
*Хүснэгт 6 СВОТ шинжилгээ* .... 27
*Хүснэгт 7 Орон тооны ажилчид* .... 29
*Хүснэгт 8 Хувьцаа эзэмшигчид* .... 30
*Хүснэгт 9 ТУЗ-н гишүүд* .... 32
*Хүснэгт 10 Удирдлагын багийн гишүүд* .... 32
*Хүснэгт 11 Баланс* .... 36
*Хүснэгт 12 Орлогын тайлан* .... 37
*Хүснэгт 13 Хөрөнгийн үнэлгээний нэгтгэл* .... 38
*Хүснэгт 14 Бизнесийн үнэлгээний нэгтгэл* .... 39
*Хүснэгт 15 Хувь нийлүүлэгчдийн хөрвүүлэн эзэмших хувьцааны ширхэг* .... 47
*Хүснэгт 16 Анхдагч зах зээлд байршуулах график* .... 50
*Хүснэгт 17 Хөрөнгийн зарцуулалт* .... 54
*Хүснэгт 18 Тоног төхөөрөмжийн зарцуулалт* .... 56
*Хүснэгт 19 Байгууламжийн зарцуулалт* .... 56
*Хүснэгт 20 Орлогын прогноз* .... 57
*Хүснэгт 21 Төсөвлөсөн орлогын тайлан* .... 58
*Хүснэгт 22 Орлогын зардлын бүтэц* .... 58
*Хүснэгт 23 Төсөвлөгдсөн баланс* .... 59
*Хүснэгт 24 Төсөвлөгдсөн балансын үзүүлэлтүүдийн бүтэц* .... 60
*Хүснэгт 25 Хөрөнгө оруулалтын өгөөж* .... 61

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

***Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан үгийн товчлолууд нь дараах утгыг агуулна.***

| | |
|---|---|
| ААНОАТ | Аж ахуй нэгжийн орлогын албан татвар |
| ББӨ | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг |
| БГД | Баянгол дүүрэг |
| БДК | Брокер, дилерийн компани |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| МУ | Монгол Улс |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| МХБ | Монгол Хөрөнгийн Бирж |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НББОУС | Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| СБД | Сүхбаатар дүүрэг |
| ТУЗ | Төлөөлөн Удирдах Зөвлөл |
| УБ | Улаанбаатар |
| УБТЗ | Улаанбаатар Төмөр Зам |
| ХК | Хувьцаат компани |
| ХНХ | Хувь нийлүүлэгчдийн хурал |
| ХЭХ | Хувьцаа эзэмшигчдийн хурал |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ХШЗ | Хянан шалгах зөвлөл |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| EPS | Earning Per Share /Нэгж хувьцаанд ноогдох ашиг/ |
| P/E | Price/Earning ratio /Үнэ ашгийн харьцаа/ |
| ROA | Return on assets /Нийт хөрөнгийн өгөөж/ |
| ROE | Return on equity /Эзэмшигчдийн өмчийн өгөөж/ |

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

***Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан нэр томъёонууд нь дараах утгыг агуулна.***

| | |
|---|---|
| Агуулах | Ачааг хүлээн авах, түр эсвэл удаан хугацаагаар хадгалах, боловсруулах, түгээх, хүлээлгэж өгөх зориулалт бүхий ачааны терминалийн бүтцийн үндсэн нэгж |
| Ажлын байр | Ажилчин хүн тодорхой ажилбарыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай технологийн тоног төхөөрөмж, багаж, нэмэлт хэрэгслээр тоноглогдсон ажиллах орчин |
| Ам.доллар | Америкийн Нэгдсэн Улсын мөнгөн тэмдэгт |
| Андеррайтер | Уг үнэт цаасыг олон нийтэд санал болгох ажлыг гүйцэтгэж буй "БиДиСЕК" ХК |
| Ачааны терминал | Ачааг цуглуулах, хүлээн авах, хадгалах, боловсруулах, түгээх, ачиж буулгах, мэдээлэл дамжуулах ба солилцохтой холбогдсон иж бүрдэл үйл ажиллагаа эрхэлдэг, холбогдох техникийн шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллага */Монгол улсын стандарт/* |
| Валютын ханш | Монгол Банкны тухайн өдрөөрх төгрөгийн бусад валюттай харьцах мөнгөн нэгж |
| Дотоод тээврийн хэрэгсэл | Үйлдвэр, агуулахын доторх, гаднах талбайд байх суурин болон хөдөлгөөнт, мөн ачаа цуглуулах, түгээх, хүлээлгэн өгөх үйлчилгээний хүрээнд ашиглах зориулалтын тээврийн хэрэгсэл |
| Зуучлагч | Үнэт цаасны зуучлагч андеррайтерийн компани |
| Компани | Үнэт цаас гаргагч "Э-Транс Ложистикс" компани |
| Нэг цэгийн үйлчилгээ | Ачаа бараа хүлээн авах, боловсруулах, хадгалах, түгээх, ачиж буулгах, даатгах, гаалийн бүрдүүлэлт хийх ажил, үйлчилгээг нэг цэгт гүйцэтгэх иж бүрэн ажиллагаа |
| Терминалийн тээвэрлэлт | Ачааны терминалаар дамжин зохион байгуулагдаж тэдгээрийн хооронд хийгдэх тээвэрлэлт, |
| Технологи ажиллагаа | Аливаа ажил, үйлчилгээний ажилбарыг техникийн шаардлагын дагуу гүйцэтгэх тогтоосон дараалал |
| Төгрөг | Монгол Улсын мөнгөн тэмдэгт |
| Үнэт цаас гаргагч | Үнэт цаасаа олон нийтэд санал болгон санхүүжилт татан төвлөрүүлж буй "Э-Транс Ложистикс" компани |
| YЦТТТХТ | Монгол Улсын 100 хувийн төрийн өмчит Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв ХХК |

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Аудит | ***"Мэдээлэл-Аудит" ХХК***<br><br>*Хаяг: УБ, БГД, 17-р хороо, Амарсанаагийн гудамж, ЖиЭсДи төв №505*<br><br>*Холбоо барих утас: 369511* |
| Хууль | ***"Монгол Өмгөөлөгч" хууль зүйн фирм***<br><br>*Хаяг: УБ, СБД, 1-р хороо, Гранд оффис төв, # 201*<br><br>*Холбоо барих утас:70129206*<br><br>*Вэб сайт:* ***www.advocate.mn***<br><br>*Э-майл хаяг:* ***info@advocate.mn*** |
| Үнэлгээ | ***"Үндэсний Реалти" ХХК***<br><br>*Хаяг: УБ, ЧД, 4-р хороо, нэгдсэн үндэсний гудам, бага тойруу 6/7*<br><br>*Холбоо барих утас: 99182632*<br><br>*Э-майл хаяг:* ***b_naraa2@yahoo.com*** |
| Андеррайтер | ***"БиДиСек" Хувьцаат Компани***<br><br>*Хаяг: УБ, СБД, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, "БиДиСЕК" ХК- ийн төв оффис*<br><br>*Холбоо барих утас:11-312030*<br><br>*Вэб сайт:* ***www.bdsec.mn***<br><br>*Э-майл хаяг:* ***info@bdsec.mn*** |

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## КОМПАНИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАНД ОРОЛЦСОН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

| | *Овог нэр* | *Мэргэжил* | *Хаяг* |
|---|---|---|---|
| 1 | Ч.Энхболд | Төмөр замын инженер | "Э-Транс" ХХК-ийн Ерөнхий захирал<br>*УБ, СБД 1-р хороо ЧӨЧ 8-4* |
| 2 | Д.Даянбилгүүн | Бизнесийн удирдлага | "БиДиПиИЭф" ХХК-ийн гүйцэтгэх захирал<br>*УБ, ЧД 5 хороо, 6 хороолол 7-16 тоот* |
| 3 | Х.Батхишиг | Инженер | "BLJ"ХХК-ийн захирал<br>*УБ, БГД, 18-р хороо, 4-р хороолол, 44-78 тоот* |
| 4 | James Passin | Эдийн засагч | "Firebird Global Fund" ХХК -ийн гүйцэтгэх захирал<br>*152 West 57th Street, New York, NY 10019* |
| 5 | Ч.Амарсанаа | Уулын инженер механик | "Э-Транс Ложистикс" ХК-ийн гүйцэтгэх захирал<br>*УБ, БЗД 15-р хороо 7-19* |
| 6 | Б.Лхагвадорж | Нефьтийн инженер | "БиДиСЕК" ХК-ийн тэргүүн дэд захирал<br>*УБ, ЧД, 5-р хороо, 6-р хороолол, 7-30* |
| 7 | Б.Батбаатар | Бизнесийн удирдлага | "СиБиЭм" ХХК-ийн захирал<br>*УБ, СБД, 2-р хороо, 32-64 тоот* |
| 8 | С.Отгонбаяр | Бизнесийн удирдлага | "Э-Транс" ХХК-ийн Тээврийн мэргэжилтэн<br>*УБ, СБД, 8-р хороо, 24-93 тоот* |

*Хүснэгт 1 Шийдвэр гаргалтанд оролцсон эрх бүхий этгээдүүдийн мэдээлэл*

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



# НЭГ. КОМПАНИЙН ТУХАЙ

## 1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ХАЯГ

Хаяг: Монгол улс, Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг

Утас: +976- 025-2454-3813

Факс: +976- 11-323-754

## 1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| ***Компанийн оноосон нэр:*** | "Э-Транс Ложистикс" ХК |
| ***Байгуулагдсан огноо:*** | 2010 он 12 сар |
| ***Улсын бүртгэлийн дугаар:*** | 9019059011 |
| ***Регистрийн дугаар:*** | 3309665 |
| ***Газар эзэмших гэрчилгээний дугаар:*** | 00208339 |
| ***Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний дугаар:*** | Ү-0711001097 |
| ***Нийт эзэмшдэг газрын талбайн хэмжээ:*** | 50,000 м2 |
| ***Үйл ажиллагааны үндсэн чиглэл:*** | Ачаа шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагаа |

## 1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТҮҮХ

Үнэт цаас гаргагч компани нь 2010 оны 12 сард ачаа шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагаа эрхлэхээр 4 гишүүнтэйгээр үүсгэн байгуулагдсан. Компани 2011 оны 02 сард үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор 100 төгрөгний нэрлэсэн үнэтэй 38,490,000 ширхэг хувьцааг хаалттай хүрээнд нэмж гарган үүсгэн байгуулагч "Монголиан Транспортэйшн Холдинг" ХХК, "БиДиПиИЭф" ХХК, Х.Батхишиг нар мөнгөн хөрөнгөөр, "Э-Транс" ХХК нь ачаа шилжүүлэн ачих цогцолборын эд хөрөнгөөр хувьцаа худалдан авч дүрмийн санг 3,850,000,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн.

Компани хөрөнгө оруулалтын үр дүнд "Э-Транс" ХХК-аас терминалын үлдсэн эд хөрөнгийг худалдан авснаар Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах ачаа шилжүүлэн ачих терминалын хөрөнгө, үйл ажиллагааг бүрэн шилжүүлэн авсан. Улмаар 2011/03/01-ны өдрөөс ачаа шилжүүлэн ачих үйл ажиллагааг эхлүүлэн амжилттай ажиллаж байна.

Уг шилжүүлэн ачих терминалын төслийг "Э-Транс" ХХК 2007 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2009 онд ашиглалтанд оруулж байсан.

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТҮҮХ

***Компанийн үндсэн үйл ажиллагаа***

Үнэт цаас гаргагчийн ачаа шилжүүлэн ачих цогцолбор /терминал/ нь Монгол улсыг Хятадтай холбосон хамгийн том боомт болох Замын-Үүд боомтод 5га талбайд үйл ажиллагаа явуулж Хятад улсаас ачааны машинаар тээвэрлэгдэн импортоор ирж буй ачааг вагонд, вагоноор ирж буй ачаа барааг ачааны машинд шилжүүлэн ачих үйлчилгээ үзүүлдэг.

Терминал нь хилийн хаалганаас 100м зайд байрлан үйл ажиллагаа явуулдаг ба энэ нь хэрэглэгчдийн хувьд маш тохиромжтой байрлал юм. Үйлчлүүлэгчид БНХАУ-аас оруулж ирж буй бараа бүтээгдэхүүнээ терминалд хүлээлгэн өгснөөр түүнийг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт өөр бусад хүссэн газраасаа хүлээн авах боломжтой байдаг.

Компанийн удирдлагын багийн гишүүд тээвэр зууч, төмөр замын салбарт олон жил ажилласан туршлагатай боловсон хүчнээс бүрддэг. Сүүлийн жилүүдэд МУ-н ачаа эргэлт тасралтгүй өсч байгаатай холбоотойгоор терминалын эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Компанийн тохиромжит байрлал, ур чадвартай менежмент, хамтран ажиллах тааламжтай нөхцөл зэрэг нь үндсэн гол давуу талуудыг бий болгодог.

Терминал нь төмөр замын 2 салаа тус бүр нэг удаад 17 вагон, сард 600 вагонд ачилт хийх, жилд 1000.0 мян.тонн ачааг шилжүүлэн ачих хүчин чадалтай.

Үнэт цаас гаргагч нь шилжүүлэн ачих хугацааг бууруулах, ажиллах хүч хэмнэх, үйл ажиллагааг хялбарчлах, хүчин чадлыг нэмэгдүүлэх үүднээс төрөл бүрийн ачаа шилжүүлэн ачих дамжуурга, механикжуулалтыг нэвтрүүлж байна.

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

СЗХ 2012 он 01 сар 18 өдөр БҮРТГЭВ №01



### *Гаалийн хяналтын бүс*

Үнэт цаас гаргагчийн шилжүүлэн ачих зориулалт бүхий 5 га талбайд гаалийн хяналтын бүс байрладаг. Тус хяналтын бүсэд Гаалийн хяналтын бүс тогтоох тухай Гаалийн ерөнхий газрын даргын 2010/09/21-ны өдрийн №475-р тоот тушаалаар зөвшөөрөл олгосон.

Үнэт цаас гаргагчийн талбайд байрлах Гаалийн хяналтын бүс нь 2011/04/01-ээс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд үйлчлүүлэгчдийн ачаа шилжүүлэн ачих үйл ажиллагааг хөнгөвчлөх үүднээс нэг цэгийн үйлчилгээ үзүүлж, дараах байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

1. Монгол улсын гааль
2. Мэргэжлийн хяналтын газар
3. Банк
4. Гаалийн бүрдүүлэлтийн зууч

Тус гаалийн хяналтын бүсээр нэвтэрч буй бараа бүтээгдэхүүний экспортлогч болон импортлогчид нь гаалийн бүрдүүлэлт хийх, Монгол улсын гаальд хянуулах, Мэргэжлийн хяналтын газраар шалгуулах, татвар хураамжаа банкинд тушаах зэрэг үйчилгээг нэг дороос авах бөгөөд Монгол улсын гаалиар нэвтэрсний дараа шууд тус талбай дээрээ Үнэт цаас гаргагчийн ачаа шилжүүлэн ачих үйлчилгээг авах боломжтой байдаг.




*Зураг 1 Хяналтын камерын байршил*

Талбайд 4 ширхэг хяналтын камер 15метрийн өндөрт байрлан ачилт буулгалтын талбайг бүрэн хяналтандаа байлгадаг. Талбайн гэрэлтүүлэгт 400ВТ 14 ширхэг, 500ВТ 4 ширхэг, нийт 18 ширхэг 400ВТ-500ВТ гэрлүүдийг байрлуулан талбайг бүхэлд нь гэрэлтүүлж байна.

3309665 ГСТ1645 Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК ДОРНОГОВЬ АЙМАГ

УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## Ачаа шилжүүлэн ачих цогцолборын авто машин байрлуулалт




Зураг 2 Авто машин байрлуулах төлөвлөгөө

Тээврийн хэрэгслийг дараах байдлаар тусгаарлан байршуулна.

- Импортын ачаа ачсан автомашин /Вагонд ачуулан орон нутагт тээвэрлэх/
- Экспортын ачаанд орох автомашин /Вагоноор ирж буй ачааг тээвэрлэн экпортлох/

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## Хяналтын камер нь



Зураг 3 Хяналтын камер

250 метрийг татах хүчин чадалтай, дээш доошоо 45 градус хазайн 355 градус эргэдэг, бичлэгийг 30 хоног хадгалж чадах 500GB багтаамжтай камеруудыг 15 метрийн өндөрт талбайг бүхэлд нь хянахаар байрлуулсан.

## Зөөврийн авто пүү


Хавсралт №2 / Дижитал авто пүү /

Зураг 4 Зөөврийн авто пүү

150 тонны дижитал авто пүү дээгүүр автомашин 3-5 км цагийн хурдтай гарахад тэнхлэг тус бүрээр нь пүүлж нийт жинг тогтоож гаргадаг.

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



**Нүүрс шилжүүлэн ачилт**





**Ачаа шилжүүлэн ачилт**



**Ачаа шилжүүлэн ачилт**



5309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

УЛААНБААТАР

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



**Тус бүр 3200 м кв бүхий 3 түр агуулах**





**Нэг цэгийн үйлчилгээний оффисын барилга**



**Монгол улсын гааль**




ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## *Дэд бүтэц*

Терминал нь авто зам, төмөр замаар олон улс болон Монгол улсын томоохон хот сууринтай холбогдсон газар зүйн өндөр ач холбогдол бүхий бүсэд байрладаг.

- Төвийн нэгдсэн цахилгаан эрчим хүчинд холбогдсон, өөрөө бие даан цэвэр бохир ус, дулаан хангамжийг шийдсэн
- Утас интернет зэрэг цахилгаан холбоо банк санхүүгийн үйлчилгээгээр бүрэн хангагдсан.
- 350 м урт төмөр замын 2 салаа,
- Тус бүр нь 1500м2 талбайтай 2 агуулах, ажилчдын байр, түр оффис, гаалийн хяналтын газар
- Нийт 5 га талбай болон бусад дэд бүтцээр бүрэн хангагдсан.

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БАЙРШИЛ

***Ачаа шилжүүлэн ачих терминал***







*Зураг 5 Терминалын байршил*

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.5 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

Монгол улсын эдийн засаг, гадаад худалдаа өргөжин, экспорт импорт болон МУ-аар дамжин өнгөрөх бараа эргэлт ихээхэн нэмэгдэж байгаагаас ачаа шилжүүлэн ачих терминалын хэрэгцээ, ач холбогдол их байна. Өнөөдөр Замын-Үүдэд байрлах ачаа шилжүүлэн ачих ангийн хүчин чадал хүрэлцээ муу байгаагаас ачаа ачуулах хүлээлгийн дараалал их, ялангуяа ачаатай машинууд Эрээнээс Замын-Үүдэд ирээд ачаагаа шилжүүлэн ачихаар урт дараалалд зогсож байна. Ачаа тээврийн оргил ачааллын үед ачаа шилжүүлэх ачих дундаж хугацаа 7-15 хоног хүлээгддэг ба энэ нь вагоны эргэлт хүрэлцээ муу, сул зогсолт их байгаатай холбоотой. Ачааг гар ажиллагаагаар шилжүүлэн ачихад цаг хугацаа их алддаг бөгөөд үүнийг механикжуулснаар вагоны сул зогсох хугацаа буурах боломжтой.

### *Гадаад хүчин зүйл болон зах зээлийн орчин*

| Улс орон /мян.ам.доллар/ | 2008 | | 2009 | | 2010 | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | % | Дүн | % | Дүн | % |
| **Гадаад худалдааны эргэлт** | **5 779 007.4** | | **4 033 896.4** | | **6 177 155.5** | |
| **Импорт** | 3 244 541.1 | 100% | 2 131 308.8 | 100% | 3 200 053.3 | 100% |
| Ази | 1 511 318.1 | 47% | 909 891.5 | 43% | 1 513 625,2 | 47,3% |
| Үүнээс: Хятад | 898 732.4 | 27.7% | 532 067.3 | 25% | 956 454.8 | 29,9% |
| **Экспорт** | 2 534 466.4 | 100% | 1 902 587.6 | 100% | 2 908 502.2 | 100% |
| Үүнээс: Хятад | 1 635 890.6 | 64.5% | 1 390 775.4 | 73% | 2 454 382,1 | 84,4% |

*Хүснэгт 2 Гадаад худалдааны эргэлт* Эх үүсвэр: Монгол улсын статистикийн эмхэтгэл

Монгол улс импортын бараа бүтээгдэхүүний дөч гаруй хувийг Ази орнуудтай тэр дундаа 2008-27.7%, 2009-25%, 2010-29,9%-ийг Хятад улсаас дангаар импортлосон бол экспортын бараа бүтээгдэхүүний 2008 – 64,5%, 2009 - 73,1%, 2010 – 84,4%-ийг Хятад улсруу экспортложээ. Ийнхүү нийт гадаад худалдааны бараа эргэлтийн 50 гаруй хувийг Хятад улстай хийж тус улстай хийж буй импортын 90 хувь, экспортын 75 орчим хувь нь Замын үүдийн боомтоор дамждаг байна.

### *Зах зээлийн хандлага*







*График 1 Гадаад худалдааны өсөлт*

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 оны 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.5. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

Монгол улсын бараа эргэлт жил ирэх тусам хурдацтай нэмэгдэж, 2008 онд 44 хувиар өссөн байна. Санхүү эдийн засгийн хямралын улмаас 2009 онд 30 хүртэл хувиар буурсан ч дэлхийн эдийн засгийн сэргэлт, Монгол эдийн засгийн нөхцөл байдлаас үзэхэд гадаад худалдааны эргэлт дахин хурдацтай өсөх төлөвтэй байна. 2011 онд манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 11306,0 сая ам.доллар үүнээс экспорт 6526.0 сая ам.доллар, импорт 4780.0 сая ам.долларт хүрч, нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 5197.4 сая ам.доллар буюу 85,1 хувь, үүний дотор экспортын хэмжээ 1871.4 сая ам.доллар буюу 64 хувь, импортын хэмжээ 3325.9 сая ам.доллар буюу 103 хувиар өсчээ. Гадаад худалдааны тэнцэл 2011 онд 1746,0 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өмнөх оныхоос -1454,4 сая ам доллараар нэмэгдсэн байна.

Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын өсөлт болон гадагш чиглэсэн уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, дотогш чиглэсэн хөрөнгө оруулалтын урсгал нь Монголын эдийн засаг тэлэхэд хувь нэмрээ оруулж байна.

### *Монгол улсын бараа тээвэр*

Монгол улсад бүх төрлийн ачаа тээвэр тасралтгүй өсч сүүлийн жилүүдэд жилд дунджаар 23% өсч, 2011 онд 43,9 сая тонн ачаа тээвэрлэсэн ба энэ нь өмнөх оныхоос 14,5 сая тонн буюу 49,46 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн онд авто тээврээр тээсэн ачаа 25,6 сая тонндхүрч өмнөх оныхоос 103,0 хувь, төмөр замаар тээсэн ачаа 1,5 сая тонн буюу 9 хувиар өсчээ.

| | 2008 | 2009 | 2010 | 2011 |
|---|---|---|---|---|
| **Бүх төрлийн тээвэр** | | | | |
| Тээсэн ачаа мянган.тн | 23904,4 | 24736,7 | 29415,9 | 43965,6 |
| Ачаа эргэлт, сая.тн.км | 9051,4 | 9016,4 | 12124,8 | 16300,2 |
| Тээврийн орлого, оны үнээр | 419196,8 | 465608,6 | 593603,6 | 756009,4 |
| **1. Авто тээвэр** | | | | |
| Тээсэн ачаа мянган.тн | 9255,7 | 10563,8 | 12610,2 | 25635,3 |
| Ачаа эргэлт, сая.тн.км | 782,1 | 1160,7 | 1834 | 4910,3 |
| Тээврийн орлого, оны үнээр | 100098,2 | 128464,1 | 172190,8 | 205478,3 |
| **2. Төмөр замын тээвэр** | | | | |
| **Тээсэн ачаа мянган.тн** | **14646,4** | **14171,6** | **16804** | **18327,5** |
| Дотоодын | 8016 | 7656 | 8304,4 | 8464,1 |
| Гаргалт | 2565 | 2955 | 4638,8 | 5948 |
| Оруулалт | 1727 | 1264 | 1546,2 | 2027,2 |
| Дамжин өнгөрөх | 2338,4 | 2296,6 | 2314,6 | 1888,2 |

*Хүснэгт 3 Монгол улсын бараа тээвэр*

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.5. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА




*График 2 Авто зам, төмөр замын тээвэр*




*График 3Төмөр замын тээвэр*

Ачаа тээвэр 2009, 2010 онуудад 57% нь төмөр замаар, 43% нь авто замаар, 2011 онд 42%нь төмөр замаар, 58% нь авто замаар тээвэрлэгдсэн байна. Төмөр замаар тээвэрлэгдэж буй тээврийн 46% нь дотоодын тээвэр, 33% нь гаргалт, 11% нь оруулалт, 10% нь дамжин өнгөрөн тээвэрлэгдэж байна.

Иймд нийт ачаа тээврийн 50 орчим хувь нь дотоодод тээвэрлэгдэн үлдсэн 50 хувь нь экспорт, импортын зориулалтаар болон Монгол улсаар дамжин өнгөрч буй ачаа бараа бөгөөд эдгээрийн өсөлт бууралт нь ачаа шилжүүлэн ачих терминалын өсөлт бууралтанд шууд нөлөөтэй юм. Сүүлийн жилүүдэд төмөр замын тээвэр нэмэгдэж байгаа нь гаргалт буюу экспортын ачаа тээвэр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### *Замын -Үүд боомт*

Монгол Хятадыг холбосон Эрээн боомтоор авто тээвэр болон төмөр замын тээврээр дамжин Замын-Үүд боомтод ачаа орж ирдэг. Сард 200 гаруй мянган тонн бараа бүтээгдэхүүн дамжин өнгөрдөг ба түүний 100 гаруй мянган тонн нь Хятадын вагонаас Монголын вагонруу дамжин ирж, харин үлдсэн тал орчим хувь нь Эрээн хотоос авто тээврээр орж ирдэг. Энэхүү боомтоор Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 70 орчим хувь нь дамжиж байна. 2009 оны судалгаагаар Замын -Үүд боомтын ачаа эргэлт - өдөрт -3.7 мянган тн, улиралд- 240 мянган тн, жилд дундажаар - 1 сая тн байна.

Замын-Үүдэд тээвэр ложистик хангалтгүй хөгжсөний улмаас бараа бүтээгдэхүүн тээвэрлэх ложистикийн үйлчилгээний өртөг тухайн барааны өртгийн 18-24 хувийг эзэлдэг. Энэ нь хэт өндөр үнэтэй байгаа ба хөрөнгө оруулагчид 12 хувиас хэтрээгүй бол үүнийг боломжийн гэж үздэг байна.

5309565 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.5. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

Замын-Үүдэд төмөр замын зүтгүүр, вагоны хүрэлцээ, хүчин чадал муу байна. Ийнхүү тээвэрлэлтийн салбарын хөгжил муу байгаа нь бусад салбарын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд саад болж байна. Тухайлбал, барилгын материалыг тасралтгүй, бага зардлаар нийлүүлэх орчин бүрдээгүй байгаа нь бага зардлаар чанартай барилга барих боломжийг хязгаарлаж байна.

### *Ачаа тээврийн үйлчилгээний хангалтгүй байдлын улмаас бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүндрэл*

2009, 2010 онуудын ачаа тээврийн оргил ачааллын үед ачаа шилжүүлэн ачихад дунджаар 7-15 хоног хүлээгдэж байна.

2007, 2008 онуудад дараах байдлаар цаг хугацаа алдаж байжээ.

*2008 он:*

- Холимог ачааг хяналт шалгалтаар оруулахад 23.5 цаг
- Ижил төрлийн ачаанд хяналт хийхэд 28.2 цаг
- Хятадад ачаа ачуулснаас эхлэн Замын-Үүдэд жинлүүлж дуустал 34.2 цаг
- Холимог ачааны 3 орчим хувьд нарийвчилсан үзлэг хийдэг

*2007 он:*

- 11 тээвэр зуучийн компани хоосон контейнерийг хугацаанд нь буцааж чадаагүйн торгуульд нэг тэрбум гаруй төгрөг төлсөн байна.
- Цемент ачсан нийт 450 орчим вагон 16-45 хоног саатсанаас УБ жижиглэнгийн үнэ нь 76 хувиар өсч байжээ.
- Ачаатай нэг машины хүлээх зардал өдөрт 70-120 мянган төгрөг байдаг ба дунджаар 20 хоног хүлээхэд барааны өртөг 1,400,000-2,400,000 төгрөгөөр нэмэгджээ.

### *Замын үүд боомтын ач холбогдол, давуу тал*

- Ази Европыг холбох хамгийн дөт зам

  /Монголоор дайруулан Европоос Зүүн Ази хүртэл тээвэрлэхэд бусад замуудаас 1135-1600 км дөт/

- МУ-ын далайд хүрэх хамгийн дөт зам
- Худалдааны хамгийн том боомт
- Замын-Үүд эдийн засгийн чөлөөт худалдааны бүс

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРГГЭВ
№ 01



## 1.5. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

### *Цаашдын дэд бүтцийн хөгжил*

***Төмөр зам:*** Замын-Үүдээр ОХУ, Монгол Улс, БНХАУ-ыг холбосон төмөр зам дайран өнгөрдөг. Замын -Үүд өртөөны нэвтрүүлэх чадвар нь Хятадын төмөр замтай өргөн царигаар ачааны 5 хос галт тэрэг, нарийн царигаар ачааны 2 хос галт тэрэг 24 цагт солилцдог. Бараа шилжүүлэн ачих байгууламжийн ачаа сэлгэн ачих нийт хүчин чадал нь өргөн (Монгол), нарийн (Хятад) төмөр замын хооронд жилд 12000 контейнер, 2520 вагон. Шингэн ачаа шилжүүлэн ачих байгууламж нь 3000 м3 бензин, 3000 м3 дизелийн түлш хадгалах багтаамж бүхий савтай, шилжүүлэн ачих хүчин чадал нь 2-3 цагт 180 тн байна.

2011/04/22-ны өдөр Даланзадгад-Сайншанд-Чойбалсан-Улаанбаатар чиглэлийн 1100 км төмөр зам тавих ажлыг эхлүүлсэн.

***Авто зам:*** Улаанбаатар Чойрыг холбосон 223 км засмал замтай бөгөөд түүнээс цааш Замын-Үүд хүртэл шороон замаар холбогддог байна.

Дараах чиглэлийн засмал замууд ашиглалтанд орохоор төлөвлөгдөж байна.

- 2012 онд Сайншанд – Замын Үүдийг холбосон хар зам
- 2013 онд Чойр – Сайншандыг холбосон засмал
- 2018 онд Алтанбулаг – Замын Үүдийг холбосон хүнд даацын авто машин явах боломжтой 1100 км хурдны зам

5309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.5. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

***Өрсөлдөгчийн судалгаа***

Үнэт цаас гаргагчийн ачаа шилжүүлэн ачих терминал нь салбартаа тухайн чиглэлийн үйлчилгээний 30 орчим хувийг эзэлж байна.

Тухай терминал нь Замын-Үүдэд ачаа шилжүүлэн ачих чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй анхны хувийн компани юм. Улсын буюу Төмөр замын харьяа шилжүүлэн ачих 3 өртөө байдаг бөгөөд тэдгээр нь дараах зориулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

| | Терминалын нэр | Зориулалт | Зай /хилийн хаалганаас/ |
|---|---|---|---|
| ***1*** | ***"Э-Транс Ложистикс" Компанийн терминал*** | ***Монголын өргөн царигийн вагон болон авто машин хооронд ачаа шилжүүлэн ачдаг.*** | ***100 метр*** |
| 2 | Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө 1 | Хятадын төмөр замын нарийн царигийн вагон, Монголын төмөр замын өргөн царигийн вагоны хооронд ачаа шилжүүлэн ачих зориулалттай болович мөн авто машин вагон хооронд ачаа шилжүүлэлт хийдэг. | 6 км |
| 3 | Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө 2 | Контейнер машин механизмын шилжүулэн ачих зориулалттай | 4 км |
| 4 | Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө 3 | Монголын өргөн цагирагын вагон болон авто машин хооронд ачаа шилжүүлэн ачдаг. | 11 км |

*Хүснэгт 4 Өрсөлдөгчийн судалгаа*

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.5. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

### *"Э-Транс Ложистикс" компанийн SWOT шинжилгээ*

Үнэт цаас гаргагч нь дараах SWOT шинжилгээнд авч үзсэн давуу тал боломж дээрээ тулгуурлан хөрөнгийн санхүүжилтийг шийдвэрлэн техникийн шинэчлэл, үйлчилгээ үзүүлэх хүчин чадлаа нэмэгдүүлж, шилжүүлэн ачих ачааны тоо хэмжээг нэмэгдүүлж, нэгжид ноогдох өртөг зардлыг хямдруулж, зах зээлд эзлэх байр сууриа өсгөх боломжтой.

| ***Компанийн дотоод хүчин зүйлс*** | |
|---|---|
| Давуу тал | Сул тал |
| • Замын-Үүд боомтод төмөр зам, авто замын дагуу хилийн бүсэд маш ойрхон байрладаг.<br>• Үйлчилгээ нь үйлчлүүлэгчдэд эерэгээр танигдсан бөгөөд үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж байгаа<br>• Тухайн үйлчилгээний чиглэлээр туршлагатай, чадварлаг менежмент<br>• Хурдан шуурхай, хүнд сурталгүй үйлчилгээ<br>• Өөрийн өмчлөлийн контор, үйлчилгээ, агуулахын барилга байгууламжтай, өөрийн эзэмшлийн газартай ба материаллаг бааз сайтай.<br>• Компанийн үйл ажиллагаа нь байгаль экологид сөрөг нөлөөгүй<br>• Шаардлагатай техникийн шинэчлэл хийснээр хүчин чадал, цаг ашиглалт, үйлчилгээний чанар сайжирна. | • Өөрийн гэсэн вагон байхгүй<br>• Шилжүүлэн ачих үйл явцад гар ажиллагаа ихтэй.<br>• Вагоны сул зогсолт их гардаг. |
| ***Компанийн гадаад хүчин зүйлс*** | |
| Боломж | Аюул |
| • Эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор барилга, хөдөө аж ахуй, хүнс гэх мэт салбарууд сэргэж байгаатай холбоотойгоор Замын-Үүд боомтоор нэвтрэх ачаа эргэлт нэмэгдэх хандлагатай байна.<br>• Ирээдүйн эдийн засаг, бараа эргэлтийн өсөлт<br>• Хөрөнгө оруулалтын сэргэлтийн үе<br>• Замын үүдийг эдийн засгийн чөлөөт бүс болгох тухай хөтөлбөр<br>• Дэд бүтцийн хөгжил | • Байгаль, гэнэтийн үзэгдлээс үүсч болох зарим эрсдэл<br>• Онцгой нөхцөл байдлаас шалгаалан хил гааль хаагдах<br>• Эдийн засгийн хямрал, барилгын салбарын зогсонги байдлаас шалтгаалж ачаа тээврийн эргэлт буурдаг, хүчин чадлаа бүрэн ашиглаж чадахгүйд хүрдэг. |

*Хүснэгт 5 СВОТ шинжилгээ*

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал байна. Хувь нийлүүлэгчдийн хурлаар хуульд заасан асуудлууд болон Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагаас өргөн барьсан аливаа асуудлуудыг хэлэлцэнэ. Хувь нийлүүлэгчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаас бусад тохиолдолд Компанийн удирдлага болон бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ. ТУЗ-ийн гишүүдийг компанийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар хувь нийлүүлэгчдийн санал хураалтаар сонгоно.

### *Хувьцаа эзэшигчдийн бүтэц /хувиар/*




*График 4 Хувьцаа эзэмшигчдийн бүтэц*

### *Компанийн бүтэц зохион байгуулалт*




*Зураг 6 Компанийн бүтэц зохион байгуулалт*

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь хувь нийлүүлэгчдийн чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг бодлогоор удирдан чиглүүлж, хянан залж, хариуцлага хүлээдэг засаглалын нэгж юм.

Гүйцэтгэх захирал нь компанийн гүйцэтгэх удирдлагын дээд албан тушаалтан байх ба компанийн өдөр дутмын үйл ажиллагаа, хувь нийлүүлэгчдийн болон ТУЗ-ийн хурлын бүх тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилладаг.

### *Ажиллагсдын судалгаа*

"Э-Транс Ложистикс" компани нь орон тооны 18 ажилчин, өдөрт орон тооны бус 70-80 ачигчдыг ажлын байраар хангаж ажиллаж байна.

| № | Орон тооны ажилчид | Тоо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэх захирал | 1 |
| 2 | Ачаа тээврийн менежер | 2 |
| 3 | Аж ахуй хариуцсан менежер | 1 |
| 4 | Санхүү эрхэлсэн менежер | 1 |
| 5 | Механикч | 1 |
| 6 | Пүүлэгч | 6 |
| 7 | Нягтлан бодогч | 1 |
| 8 | Касс, нярав | 1 |
| 9 | Аж ахуйн ажилчид | 3 |
| 10 | Жолооч | 2 |
| | *Нийт* | *18* |

*Хүснэгт 6 Орон тооны ажилчид*

Хоногийн 24 цагт 1 ээлжийн ахлагч, 2 гэрээт харуул, 2 пүүлэгч, тээврийн мэргэжилтэн нар 3 ээлжээр ажилладаг.

***Гүйцэтгэх захирал:*** Терминалын өдөр дутмын үйл ажиллагаа, Эрээний төмөр замтай хамтран ажиллах, шаардлагатай вагоны тоо хэмжээг зохицуулах, ажилчдын аюулгүй байдалд хяналт тавих, тоног төхөөрөмжийн ашиглалтыг хянах зэргийг хариуцан ажилладаг.

***Ачаа тээврийн менежер:*** Терминалын өдөр дутмын үйл ажиллагааг бүхэлд нь хариуцан, ажлын гүйцэтгэл, ачиж буулгах хүчин чадал зэрэгт хяналт тавьж ажилладаг.

***Ээлжийн ахлах пүүлэгч:*** Ачаа тээвэрлэлтийн өдөр дутмын үйл ажиллагааг хариуцан, үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих, ажилчдын аюулгүй байдлыг хангаж ажиллана.

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.7 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИ, ТОЛГОЙ КОМПАНИ, ХЯНАЛТЫН БАГЦ ЭЗЭМШИГЧИД, ТЭДГЭЭРИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### *Хяналтын багц эзэмшигчид*

Компанийн хяналтын багцыг Э-Транс ХХК /Монгол улсын хуулийн этгээд/ болон Монголиан Транспортэйшн Холдинг ХХК /Люксембургын вант улсын хуулийн этгээд/ эзэмшдэг.

| *"Э-Транс" ХХК* | *"Монголиан Транспортэйшн Холдинг" ХХК* |
|---|---|
| Албан ёсны хаяг: БЗД, 20-р хороо, Туулын БЗД, Амгалан өртөөний байр | Албан ёсны хаяг: Люксембург Эл-2146, Руе Дэ Мэрл, 74 |
| Утас: 245908 | Утас: 212-698-9266 |
| Факс: 323754 | |

### *Үнэт цаас гаргагч компанийн хувьцаа эзэмшигчид*

| № | Үүсгэн байгуулагчид | Үйл ажиллагааны чиглэл, байршил | Эзэмшиж буй хувь |
|---|---|---|---|
| 1 | Э-Транс ХХК | Ачаа тээврийн компани, Монгол | 60,00% |
| 2 | Монголиан Транспортэйшн Холдинг ХХК | Хөрөнгө оруулалтын сан, Люксембургын вант улс | 34.28% |
| 3 | БиДиПиИЭф ХХК | Хөрөнгө оруулалтын сан, АНУ-д бүртгэлтэй | 3.90% |
| 4 | Х.Батхишиг | "BLJ" ХХК-ийн захирал | 1.82% |
| | ***Нийт гаргасан хувьцаа*** | | ***100%*** |

*Хүснэгт 7 Хувьцаа эзэмшигчид*

### *Толгой компанийн тухай мэдээлэл*

Үнэт цаас гаргагч компанийн толгой компани болох Э-Транс ХХК нь 1997 онд 1 гишүүнтэйгээр байгуулагдсан. Компанийн үүсгэн байгуулагч, ерөнхий захирал Ч.Энхболд нь төмөр замын инженер бөгөөд Замын-Үүд, Багануурын төмөр замын дэд захирал, УБ төмөр замын газрын хянагч, ачаа тээврийн салбарт ТУУШИН ХХК-д экспорт, транзит тээврийн үйл ажиллагааг 3 жил хариуцан ажилласан.

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИ, ТОЛГОЙ КОМПАНИ, ХЯНАЛТЫН БАГЦ ЭЗЭМШИГЧИД, ТЭДГЭЭРИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус компани нь төмөр зам, авто зам, агаар, далайн тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба дэлхийн 5 тивд ложистикийн байгууллагуудтай төлөөллийн гэрээгээр хамтран ажилладаг. Улаанбаатар хотод төв оффис, Замын-Үүд, Сүхбаатар аймгуудад салбартай. Бизнесийн үндсэн чиглэл нь Орос, Хятадын хооронд Монголоор дамжуулан тээвэрлэх транзит тээврийн үйл ажиллагаа юм. Үйл ажиллагаагаа эхэлснээс хойш 2500 тн бараа бүтээгдэхүүнийг төмөр зам, 100 гаруй захиалгат нислэгээр тээвэрлэсэн.

2007 оноос Ачаа шилжүүлэн ачих терминал байгуулахаар төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг терминал нь 2009 онд ашиглалтанд орсноор үйл ажиллагаагаа явуулж байна.

2011 онд Э-Транс ХХК нь ачаа шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагаагаа тусгаарлан "Э-Транс Ложистикс" ХК-д шилжүүлсэн.

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.8 ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

Компанийн тухай хуулийн 81-р зүйлд заасанаар компанийн ТУЗ-н бүрэлдэхүүн, гүйцэтгэх захирал, удирдлагын багийн гишүүд, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүд зэрэг албан тушаал эрхэлдэг этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

***Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл***

| | Овог нэр | Мэргэжил | Хаяг | Хувьцаа эзэмшдэг эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | Ч.Энхболд | Төмөр замын инженер | Э-Транс ХХК-ийн ерөнхий захирал | Үгүй |
| 2 | Ч.Амарсанаа | Уулын инженер механик | Э-Транс Ложистикс ХК-ийн гүйцэтгэх захирал | Үгүй |
| 3 | Б.Лхагвадорж | Нефьтийн инженер | БиДиСЕК ХК-ийн тэргүүн дэд захирал | Үгүй |
| 4 | Б.Батбаатар | Бизнесийн удирдлага | "СиБиЭм" ХХК-ийн захирал | Үгүй |
| 5 | С.Отгонбаяр | Бизнесийн удирдлага | Э-Транс ХХК-ийн Тээврийн мэргэжилтэн | Үгүй |

*Хүснэгт 8 ТУЗ-н гишүүд*

***Компанийн гүйцэтгэх захирал, удирдлагын багийн гишүүд, нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүдийн талаарх мэдээлэл***

| | Овог нэр | Мэргэжил | Албан тушаал | Хувьцаа эзэмшдэг эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | Ч.Амарсанаа | Геологийн инженер | Гүйцэтгэх захирал | Үгүй |
| 2 | Г.Ариунцэцэг | Нягтлан бодогч | Нягтлан бодогч | Үгүй |
| 3 | Б.Анхбилэг | Тээврийн мэргэжилтэн | Ачаа тээврийн менежер | Үгүй |
| 4 | Пүрэвсүрэн | Механикч | Аж ахуй хариуцсан менежер | Үгүй |
| 5 | Мөнх-Од | Тээврийн мэргэжилтэн | Ачаа тээврийн менежер | Үгүй |

*Хүснэгт 9 Удирдлагын багийн гишүүд*

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.9 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

"Э-Транс Ложистикс" ХК нь зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн хувьцаагаа олон нийтэд санал болгон арилжаалсны дараа хувь нийлүүлэгчдийн хурлаа зарлан дүрэм болон засаглалын журмуудыг хэлэлцэн батална. Иймээс "Э-Транс Ложистикс" ХК-ийн дүрмийн төсөл, "Ногдол ашиг хуваарилах журам"-ын төсөлд тусгасан хувьцаа эзэмшигчийн эрх, ногдол ашгийн бодлогын талаарх мэдээллийг оруулав.

***Дүрмийн төсөлд:***

- Компани нь жил бүрийн үйл ажиллагааны цэвэр ашгийг төсөвлөж зарцуулна. Үүнд: Урт богино хугацааны хөрөнгө оруулалт, компанийн ажиллагсдын нийгмийн асуудал, шагнал, урамшил, компанийн эрх бүхий албан тушаалтанд олгох шагнал урамшуулал, компанийн хувь нийлүүлэгч нарт олгох ногдол ашиг зэрэг болно.
- Компанийн жилийн цэвэр ашгийн 20-оос доошгүй хувийг ногдол ашигт хуваарилж байна.

***"Ногдол ашиг хуваарилах журам"-д***

***Ногдол ашгийн бодлого***

- Компани нь хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой захиран зарцуулж, жил бүр ногдол ашгийн хэмжээг өсгөн зохистой түвшинд байлгах зорилготой ажиллана.
- Компанийн ногдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ хэлэлцэн батлана.
- Компани тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилаж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө танилцуулана.
- Компанийн үйл ажиллагааны ашгаас хөрөнгө оруулагчдад ногдол ашиг хуваарилахдаа ногдол ашгийг бэлэн мөнгө, үнэт цаас, биет эд хөрөнгөөр олгож болно.
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-н шийдвэрийг нийтэд мэдээлэх ёстой бөгөөд уг мэдээлэл нь ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн ойлголт өгөхүйц байх ёстой.

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.9. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

***Ашгийн хэмжээг тодорхойлох***

- Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг болдог учраас энэ шийдвэр нь компанийн бодит байдлыг зөв тусгасан үзүүлэлт байна.
- Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байна.
- Бэлэн мөнгөнөөс бусад хэлбэрээр ногдол ашиг тараах тохиолдолд тухайн эд хөрөнгө, үнэт цаасны үнэлгээг ТУЗ-аас тогтооно.

***Ногдол ашиг хуваарилах***

- Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох цаг хугацаа нь компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.
- Компани хувьцаа эзэмшигчиддээ бэлэн мөнгөөр ногдол ашиг хуваарилахдаа хөрөнгө оруулагчдын үнэт цаасны дансаар дамжуулан нэгдсэн журмаар олгоно.
- Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ногдол ашиг олгож эхлэх, дуусах хугацааг тодорхой зааж, тогтоосон хугацаандаа бүрэн олгож дуусдаг байна.
- Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх хүртэлх хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь уг хувьцааны хуучин эзэмшигч этгээдэд үлдэнэ.
- Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаандаа ногдол ашгаа төлөх үүрэгтэй.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК



УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.10 БУСАДТАЙ БАЙГУУЛСАН СОНИРХОЛЫН ЗӨРЧИЛТЭЙ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Компани олон нийтэд үнэт цаас санал болгон гаргах үйл ажиллагаатай холбогдуулан "Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох худалдах тухай журам"-д заасны дагуу "Монгол өмгөөлөгч" ХХК хууль зүйн фирмтэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ 2011/04/20-ны өдөр байгуулан ажилласан. Уг гэрээний дагуу хуульчид компанийн холбогдох материалуудтай танилцсаны үндсэн дээр дараах чиглэлээр хараат бус дүгнэлт гаргасан.

### ХУУЛИЙН КОМПАНИЙН ДҮГНЭЛТЭЭР

***Дүрэм, журам, гэрээ, хэлцэл нь үнэт цаас гаргагчийн болон хөрөнгө оруулагчдын ашиг сонирхол, үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, СЗХ-оос тогтоосон журмуудад нийцэж байгаа эсэх талаар:***

"Э-Транс Ложистикс" ХХК-ийн дүрмийг компанийн тухай хуулийн холбогдох зүйл заалтад болон компанийн засаглалын кодекст нийцүүлж боловсруулсан байна.

Мөн компани олон нийтэд хувьцаагаа санал болгож, нээлттэй компани болох бэлтгэл ажлын хүрээнд "Э-Транс ложистикс" ХК-ийн дүрэм болон компанийн засаглалын 5 журмын төслийг ирүүлсэн байна. Эдгээр баримт бичгийн төсөл нь Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд болон Компанийн засаглалын кодекст нийцэж, боловсруулагдсан байна.

***Сүүлийн 3 жилд хийсэн хэлцлийн дотор их хэмжээний хэлцэл байгаа эсэх талаар:***

Үнэт цаас гаргагч компани нь 2011 оны 12 сард үүсгэн байгуулагдснаас хойш ямар нэгэн их хэмжээний хэлцэл хийгээгүй байна.

***Сүүлийн 3 жилд хийсэн хэлцлийн дотор сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа эсэх талаар:***

Хууль зүйн компанид дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн гэрээнүүдээс дараах гэрээнүүд нь Компанийн тухай хуулийн 86 дугаар зүйлд зааснаар сонирхолын зөрчил бүхий хэлцлүүд байна.

- Э-Транс Ложистикс ХХК болон Э-Транс ХХК-ийн хооронд байгуулсан газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ (2011/02/01)
- Э-Транс Ложистикс ХХК болон Э-Транс ХХК-ийн хооронд байгуулсан үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ (2011/02/01)
- Э-Транс Ложистикс ХХК болон Э-Транс ХХК-ийн хооронд байгуулсан Зээлийн гэрээ (2011/04/19)

Эдгээр сонирхлын зөрчил бүхий хэлцлүүд нь Компанийн хуульд зааснаар Төлөөлөн удирдах зөвлөлөөсөө зөвшөөрөл авч, хуулийн дагуу байгуулагдсан байна.

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.11 КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

| БАЛАНСЫН ЗҮЙЛ | 2011/01/01 | 2011/06/31 |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 1 000 000 | 12 369 494 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | | |
| Үнэлгээний хасагдуулга | | |
| Дансны авлага | | |
| Найдваргүй авлагын хасагдуулга | | |
| Бусад авлага | | |
| Бараа материал | | |
| Хангамжийн материал | | 4 176 736 |
| Урьдчилж төлсөн зардал /тооцоо | | |
| Дуусаагүй үйлдвэрлэл | | |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **1 000 000** | **16 546 230** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Барилга байгууламж | | 3 664 090 978 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (30 494 318) |
| Машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл | | 344 003 098 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (11 434 922) |
| Эд хогшил | | 16 804 540 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (837 961) |
| Бусад үндсэн хөрөнгө | | 823 000 000 |
| Хуримтлагдсан элэгдэл | | |
| Дуусаагүй барилга | | |
| Биет бус хөрөнгө | | 119 600 000 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (3 986 667) |
| Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө | | |
| Үнэлгээний хасагдуулга | | |
| **Эргэлтийн хөрөнгийн бус хөрөнгийн дүн** | | **4 920 744 748** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **4 937 290 978** |
| **Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч** | | |
| **ӨР ТӨЛБӨР** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | | 72 017 000 |
| Цалингийн өглөг | | |
| Орлогын албан татварын өглөг | | 5 274 583 |
| ХАОАТ-ын өглөг | | 487 221 |
| НӨАТ-ын өглөг | | |
| Бусад татварын өглөг | | |
| ЭМНД-ийн шимтгэлийн өглөг | | 1 243 619 |
| Ногдол ашгийн өглөг | | |
| Банкны богино хугацаат зээл | | |
| Бусад өглөг | | |
| Урьдчилж орсон орлого | | |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | | **79 022 423** |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | **-** |
| **Өр төлбөрийн нийт дүн** | | **79 022 423** |
| Эзэмшигчдийн өмч | | |
| б/хувийн | 1 000 000 | 3 850 000 000 |
| Халаасны хувьцаа | | |
| Хувьцаат капиталын дүн | 1 000 000 | 3 850 000 000 |
| Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | | 942 600 000 |
| Хуримтлагдсан ашиг /алдагдал | | 65 668 555 |
| Тайлангийн үеийн | | 66 568 555 |
| Өмнөх үеийн | | (900 000) |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **1 000 000** | **4 858 268 555** |
| **Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн** | **1 000 000** | **4 937 290 978** |

***Хүснэгт 10 Баланс***



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
ТТА...

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.11 КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

| БАЛАНСЫН ЗҮЙЛ | 2011/06/30 |
|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны орлого** | |
| **Борлуулалтын орлого** | **216 549 202** |
| Борлуулалтын хорогдол ба буцаалт | |
| **Борлуулалтын хөнгөлөлт** | |
| **Борлуулалтын орлогын дүн** | **216 549 202** |
| **Борлуулсан бүтээгдэхүүний өртөг** | **121 162 809** |
| **Нийт ашиг /алдагдал/** | **95 386 393** |
| Үйл ажиллагаа /борлуулалт, ерөнхий удирдлага/-ын зардал | |
| Үндсэн болон нэмэгдэл цалин | 3 433 324 |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 377 666 |
| Засвар үйлчилгээний зардал | |
| Ашиглалтын зардал | |
| Түрээсийн зардал | |
| Албан томилолтын зардал | 1 261 085 |
| Тээврийн зардал | |
| Түүхий эд материалын зардал | |
| Элэгдлийн зардал | 375 000 |
| Зар сурталчилгааны зардал | |
| Шуудан, холбооны зардал | 439 850 |
| Шатахууны зардал | 1 083 400 |
| Найдваргүй авлагын зардал | |
| Шагнал урамшууллын зардал | |
| Зээлийн хүүгийн зардал | |
| Бусад зардал | 14 451 007 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил | |
| **Үйл ажиллагааны зардлын дүн** | **21 421 332** |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/** | **73 965 061** |
| Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/ | |
| Үндсэн бус үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг /алдагдал | |
| Торгууль, хөнгөлөлтийн ашиг /алдагдал/ | |
| Ногдол ашгийн орлого | |
| Валютийн ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг /алдагдал/ | |
| Хувьцаа, бондын зардлын хорогдуулга | |
| Хараат болон хамтарсан үйлдвэрээс олсон ашиг | |
| Бусад | |
| Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/-ын дүн | - |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/** | **73 965 061** |
| **Орлогын татварын зардал** | **7 396 506** |
| **Татварын дараах ашиг /алдагдал/** | **66 568 555** |

*Хүснэгт 11 Орлогын тайлан*

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК



УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.12 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН БОЛОН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Компанийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг 9011119040 улсын бүртгэлийн дугаар, 19 тоот хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ бүхий "Үндэсний Реалти" ХХК-аар хөрөнгийн үнэлгээг 2011/02/28-ны байдлаар гүйцэтгүүлсэн.

### *Хөрөнгийн үнэлгээний нэгтгэл*

Компанийн Дорноговь аймгийн Замын-Үүд суман дах ачаа тээврийн цогцолборын хөрөнгийг Олон Улсын Стандарт Үнэлгээний дагуу хүлээн зөвшөөрөгдсөн аргууд болох орлогын хандлагын арга, зарлагын хандлагын арга, зах зээлийн хандлагын аргуудыг ашиглан хөрөнгийн төрөл тус бүр дээр өнөөгийн үнэлгээг тодорхойлж гаргасан байна.

Цогцолборын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн өнөөгийн үнэлгээг 2011/02/28 өдрийн байдлаар нийт 4,674,800,600.00 төгрөгөөр тогтоосныг товчоолон доорх хүснэгтэд үзүүллээ.

| | ***Хөрөнгийн нэр*** | ***Үнэлгээ /мян.төг/*** |
|---|---|---|
| 1 | Барилга | 1,698,800.0 |
| 2 | Байгууламж | 1,946,200.0 |
| 3 | Машин тоног төхөөрөмж | 160,800.0 |
| 4 | Тавилга, эд хогшил | 27,845.6 |
| 5 | Тээврийн хэрэгсэл | 17,000.0 |
| 6 | Компьютер дагалдах хэрэгсэл | 1,155.0 |
| | **Дүн** | **3,851,800.6** |
| 7 | Газар эзэмших эрх | 823,000.0 |
| | ***Нийт дүн*** | ***4,674,800.6*** |

*Хүснэгт 12 Хөрөнгийн үнэлгээний нэгтгэл*

### *Бизнесийн үнэлгээний нэгтгэл*

"Э-Транс Ложистикс" ХХК нь шинээр үнэт цаас гарган олон нийтэд санал болгох болсонтой холбоотойгоор "Үндэсний Реалти" ХХК нь тус компанийн бизнесийн үнэлгээ буюу нэгж хувьцааны зах зээлийн өнөөгийн үнэлгээг 2011/02/28-ны өдрөөр тасалбар болгон Олон улсын үнэлгээний стандарт, арга хандлага, аргачлалын дагуу бие даасан хараат бус байдалд хийж гүйцэтгэсэн.

Бизесийн үнэлгээний тайланг дараах хандлагуудаар үнэлсэн.

- Өртгийн хандлагын арга
- Орлого капиталжуулалтын хандлага
- Зах зээлийн харьцуулалтын хандлага

Бизнесийн үнэлгээний зорилго зориулалтаас хамаарч үнэлгээний арга сонголт, үр дүн, давуу болон дутагдалтай талуудыг шинжилж үзээд ирээдүйн цэвэр мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох аргаар хийсэн бизнесийн үнэлгээнд 60%-ийн ач холбогдол өгсөн. Өртгийн хандлагын аргаар үнэлгээг хийхдээ тухайн бизнесийн үйл ажиллагаа нь өөрчлөн зохион байгуулагдах, татан буугдахгүй цаашид

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.12 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН БОЛОН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

үргэлжлэх учир цэвэр хөрөнгийн аргаар хийсэн үнэлгээнд 40%-ийн ач холбогдлыг тус тус өгч бизнесийн үнэлгээг хийсэн байна.

| | *Үнэлгээний арга* | *Үнэлгээ /мян.төг/* | *Ач холбогдол* | *Тооцсон дүн /мян.төг/* |
|---|---|---|---|---|
| 1 | Цэвэр хөрөнгийн үлдэгдлийн арга | 4,677,154.8 | 40% | 1,870,861.9 |
| 2 | ЦМГ хорогдуулан тооцох арга | 6,292,084.6 | 60% | 3,775,250.8 |
| 3 | Зах зээлийн харьцуулалтын арга | | | |
| | ***Дүн*** | ***10,969,239.4*** | ***100%*** | ***5,646,112.7*** |

*Хүснэгт 13 Бизнесийн үнэлгээний нэгтгэл*

Бизнесийн үнэлгээний ажил, тооцоо, судалгаа, шинжилгээний дүнд гарсан үр дүнг үнэт цаас гаргагчийн 100 хувийн өмчийн бизнесийн өнөөгийн үнэ цэнийг дунджаар 5,646,112.7 мянган төгрөгөөр тооцсон.

Бизнесийн үнэлгээ хийсэн 2011/02/28 өдрөөр үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн капиталын бүрдүүлж буй 38,500,000 ширхэг энгийн хувьцааны нэгжийн зах зээлийн үнийг 147 төгрөгөөр тооцож гаргасан байна.

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.13 ҮНЭТ ЦААС ГАРГАН САНХҮҮЖҮҮЛЖ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагч компани нь ачаа шилжүүлэн ачих Терминалын үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай дараах зөвшөөрлүүдийг авсан.

- Үнэт цаас гаргагч нь 2010/12/17-ны өдөр ачаа шилжүүлэн ачих үндсэн үйл ажиллагааны чиглэл болон 3,850,000,000 төгрөгийн дүрмийн сантайгаар 9019059011 бүртгэлийн дугаар бүхий Улсын бүртгэлийн гэрчилгээг авсан.

- Үнэт цаас гаргагч нь "Төмөр замын тээврийн тухай" хууль, Монгол улсын холбогдох стандарт, Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн шаардлагыг хангасан учир "Улаанбаатар төмөр зам"-аас дагнасан хэрэглээний салбар зам ашиглахыг зөвшөөрч 2011/03/03 өдөр Код О-2-3, №119 тоот төмөр замын тээврийн обьектын гэрчилгээ олгосон.

- Үнэт цаас гаргагч нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1-р багт байрлах 50000 $м^2$ газрыг 15 жилийн хугацаатайгаар үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэхээр 0208339 дугаар бүхий газар эзэмшихээр эрхийн гэрчилгээг авсан.

- Ачиж буулгах цогцолборын зориулалттай агуулах, 402 м, 365 м урттай 2 салаа төмөр зам, харуулын байр /1,2/, ахуйн барилга зэрэг Ү-0714001097 дугаарт үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг авсан.

- Гаалийн Ерөнхий Газрын даргын №475 тоот тушаалаар компанийн Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1-р багт байрлах барааг шилжүүлэн ачих зориулалт бүхий 5 га талбайг гаалийн хяналтын бүсээр тогтоосон.

***Үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй холбоотой дараах хууль, журам, стандартуудыг дагаж мөрдөнө.***

### I. АЧААНЫ ТЕРМИНАЛЫН МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Стандарчлал, Хэмжилзүйн Үндэсний зөвлөлийн 2007/12/20 өдрийн №58 тоот тогтоолоор улс хоорондын болон хот хооронд тээвэрлэх ачааг хүлээн авах, боловсруулах /савлах, багцлах, ангилах г.м/, хадгалах, түгээх, ачих, буулгах зэрэг үйл ажиллагааг эрхлэх, зохион байгуулахад дагаж мөрдөх нийтлэг журам тогтоох, төрийн захиргааны болон бусад байгууллагаас хяналт тавих, ажил үйлчилгээнд үүсэх харилцааг зохицуулах стандартыг батласан. Уг стандартын хүрээнд

#### *Ачааны Терминалд тавих шаардлага*

- Улс хоорондын холимог тээвэрлэлтэнд ачааны терминал нь ачааг цуглуулах, хүлээн авах, хадгалах, боловсруулах, түгээх, ачиж буулгах, мэдээлэл цуглуулах, дамжуулах ба солилцох, даатгал, гаалийн бүрдүүлэлт хийх зэрэг нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх дотоод бүтэцтэй байна.

- Ажил үйлчилгээ явуулахдаа хүрээлэн буй орчин, хүн амд сөрөг нөлөө үзүүлэхгүй, галын болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан,

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.13 ҮНЭТ ЦААС ГАРГАН САНХҮҮЖҮҮЛЖ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

- Хөдөлмөрийн эрүүл ахуй, тав тухтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлсэн байна.

- Терминал нь дотооддоо техникийн аюулгүй ажиллагаа, үйлчилгээний соёл, ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын стандарт, заавар, журмыг мөрдөнө.

- Үйлчилгээний танхим, ажлын байр, техник хэрэгслээр хангагдсан, олон улсын болон дотоодын мэдээлэл, холбооны сүлжээнд холбогдсон байна.

- Тээврийн хэрэгсэл, өргөх, зөөвөрлөх хэрэгслийн техникийн үйлчилгээ, засварын байр зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжтэй байна.

- Ачааны терминал нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын дараах барилга, байгууламж, техникийн баазтай байна. Үүнд:
  - албан ажлын болон үйлчилгээний барилга,
  - агуулах, түүний байгууламжууд,
  - үйлчилгээний зам, талбай, зогсоол,
  - өргөж зөөвөрлөх болон технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тэдгээрийн техникийн баазаар хангагдсан байх.

## II. ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН ЖУРАМ

Гаалийн ерөнхий газрын даргын 2008/10/06 өдрийн №619 тоот тушаалаар Гаалийн Хяналтын бүсийн журмыг баталсан.

***Гаалийн хяналтын бүсд тавигдах шаардлага***

- Гаалийн хяналтын бүсэд орох, гарах хаалганаас бусад газраар бараа, тээврийн хэрэгсэл, бие хүн нэвтрэх боломжийг хаасан хашаа татсан байна.

- Гаалийн хяналтын бүс нь Монгол улсын стандарт /MNS 5832:2007/-д нийцсэн байх

- Чингэлэгээр тээвэрлэгдсэн бараа тээврийн хэрэгслийг шалгах гаалийн хяналтын бүсийн хэмжээ нь гаалийн хяналт шалгалт явуулах шаардлага хангасан байх

- Төмөр замын дагуу байрлах гаалийн хяналтын бүс нь ачиж буулгах барааны хэмжээ, нэр төрөл, тээврийн хэрэгслийн тоог улирал бүрийн эхний сарын 10-ны дотор харьяалах гаалийн байгууллагад өгч сараар тодотгол хийж байх

- Гаалийн байгууллагатай мэдээллийн сүлжээнд холбогдон гаалийн хяналтын бүсэд гаалийн хяналт тавихад шаардагдах техник, тоног төхөөрөмж суурилуулсан байна.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01


## 1.13 ҮНЭТ ЦААС ГАРГАН САНХҮҮЖҮҮЛЖ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

- Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа эрхлэгч гаалийн хяналтын бүсэд оруулсан, гаргасан бараа, тээврийн хэрэгслийн мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 5-ны дотор хяналт тавьж буй гаалийн байгууллагад гаргаж өгнө.

***Гаалийн хяналтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.***

- Гаалийн хяналтын бүсэд зөвшөөрөгдснөөс бусад газраар нэвтрэх бараа, тээврийн хэрэгсэл хүн нэвтрүүлэх
- Гаалийн хяналтын бүсэд гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй бараа тээврийн хэрэгсэл хүн нэвтрүүлэх
- Гаалийн байгууллагаас зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулах
- Гаалийн хяналтын бүс, гаалийн хилийг тодорхойлсон анхааруулга, тэмдгийг эвдэх, гэмтээх, өөрчлөх, хяналтын бүсэд нийгмийн хэв журам алдагдуулах
- Гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр аж ахуйн зориулалтаар байр талбай түрээслүүлэх, аж ахуйн үйл ажиллагаа явуулах

### III. ДАГАЖ МӨРДӨХ БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖУУД

*Хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж:*

1. Иргэний хууль,
2. Хөдөлмөрийн тухай хууль,
3. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль,
4. Нийгмийн даатгалын тухай хууль,
5. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
7. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль
8. Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ыг тогтоол
9. ЗГ-ын тогтоол Журам батлах тухай "Ажлын цагийг нэгтгэн бодох журам", "Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм",
10. Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах журам /Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал/ г.м

Хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн зорилго нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан эрх тэгш байдлыг хангахад оршино.

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 1.13 ҮНЭТ ЦААС ГАРГАН САНХҮҮЖҮҮЛЖ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

*3. Аж ахуйн нэгж, байгууллагын татвартай холбоотой харилцаа нь дараах хууль тогтоомжоор зохицуулагдаж байна.*

Эдгээрээс дурьдвал,

1. Татварын ерөнхий хууль,
2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль,
3. Онцгой албан татварын тухай хууль,
4. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль,
5. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай,
6. Татварын өршөөл үзүүлэх тухай хууль,
7. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
8. ҮТЕГ-ын даргын тушаал "Аргачлал батлах тухай" /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх аргачлал/ г.м

Татварын ерөнхий хуулиар Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар төлөгч болон татварын албаны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар аж ахуйн нэгж, байгууллагын дараах төрлийн орлогод албан татвар ногдоно:

I. Үйл ажиллагааны орлого /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-8.1.11-т заасан орлого/
II. Хөрөнгийн орлого /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.1.1-9.1.4-т заасан орлого/
III. Хөрөнгө борлуулсны орлого /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 10.1.1-10.1.2/

Онцгой албан татварын тухай хуулиар эх орны үйлдвэрийн болон импортоор авсан зарим бараа, түүнчлэн төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж болон энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдэд онцгой албан татвар ногдуулна. Зарим бараа гэдэгт бүх төрлийн согтууруулах ундаа, бүх төрлийн тамхи, автобензин, дизелийн түлш суудлын автомашин хамаарна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар дор дурьдсан бараа, ажил, үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татварыг 0-10 хувиар тооцож ногдуулна. Үүнд:

I. Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа;
II. худалдах, хэрэглэх буюу ашиглах зориулалтаар Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаад улсад экспортолсон бүх төрлийн бараа;
IV. Худалдах, хэрэглэх буюу ашиглах зориулалтаар гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрт импортолсон бүх төрлийн бараа;
V. Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ.

Мөн хуульд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, татвар ногдох боловч "тэг" хувь байх бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг тусгасан байна.

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

## 2.1. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| ***Үнэт цаасны нэр:*** | "Э-Транс Ложистикс" ХК |
| ***Хувьцааны төрөл:*** | Энгийн |
| ***Үнэт цаасны хэлбэр:*** | Биет бус |
| ***Үнэт цаасны нэрлэсэн үнэ:*** | 100 |
| ***Үнэт цаасны нийт тоо ширхэг:*** | 46,200,000 |
| ***Хөрвөх үнэт цаасны тоо ширхэг:*** | 38,500,000 |
| ***Нийтэд санал болгох хувь:*** | 16,67% |
| ***Нийтэд санал болгох үнэт цаасны тоо ширхэг:*** | 7,700,000 |
| ***Анхдагч зах зээлд байршуулах:*** | Нийт хувьцааны 16,6% буюу 7,700,000 ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар анхдагч зах зээлд олон нийтэд байршуулна. |
| ***Санал болгох үнэ:*** | Үнэт цаасыг олон нийтэд санал болгох доод үнэ 120 төгрөг байна. |

## 2.2. НЭМЖ ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ШИЙДВЭР

Монгол улсын "Компанийн тухай хууль"-ийн 43, 63-р зүйл, компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн Үнэт цаас гаргагчийн 2011/03/31-ны өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын 01, 02 тоот тогтоолын дагуу хувьцаагаа олон нийтэд санал болгон дүрмийн сангаа нэмэгдүүлж, компанийн зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулна.

2011/03/31-ны өдрийн 03 тоот тогтоолоор компанийн хувьцаа эзэмшигчид нь тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй бөгөөд шинээр гаргаж буй 7,700,000 ширхэг хувьцааг 100% олон нийтэд санал болгоно.

5309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 2.3. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын "Компанийн тухай" хууль, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулиудад заасан болон компанийн дүрэмд заасан дараах эрхтэй.

1/ Компанийн хувь нийлүүлэгчдийн хурал зарлах эрх бүхий этгээдээс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувь нийлүүлэгчийн хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;

2/ ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль, журамд заасан хугацаандаа компанийн буруутай үйл ажиллагаанаас болж олгохгүй бол алданги төлөхийг шаардах;

3/ Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;

4/ Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй. Энэ давуу эрхийг эдлэх боломжийг Компанийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ хангана.

1. Хувь нийлүүлэгчдийн хурлаар доорх асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр компанийн дүрэмд заасан үндэслэл, журмаар өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Үүнд:

   1/ Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;

   2/ Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;

   3/ Компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

2. Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг хөндлөнгийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно. ТУЗ-өөс тогтоосон үнэ нь үнэлгээний байгуулагын дүгнэлтэд заасан үнээс доогуур байж болохгүй.

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 2.3 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

3. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч болон эзэмшигчид нь жил бүрийн 2 дугаар сарын 1-нээс өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д нэр дэвшүүлэх эрхтэй.
4. Компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон бусадтай хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш 30 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдэл ирүүлэх нь компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд асуудал хэлэлцүүлэхээр оруулах тухай энэ дүрэмд заасан эрхээ эдлэх баталгаа болно.
5. Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4 болон 96 дугаар зүйлийн 96.1, 96.2-д заасан бичиг баримтуудтай энгийн хувьцаа эзэмшигч бүр танилцах эрхтэй.
6. Энгийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцааг эзэмшигчид нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх эрхтэй.
7. Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.
8. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.
9. Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувьцаа эзэмшигчдийн хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс зааглагдсан болно.

5309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
ДОРНОГОВЬ АЙМАГ



УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 2.4. ҮНЭТ ЦААСЫГ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ГРАФИК:

***Компанийн 16,67%-ийг анхдагч зах зээлд байршуулах хэлбэр***




*Зураг 7 Анхдагч зах зээлд байршуулах график*

Компанийн 2011/03/31 өдрийн ХНХ-ын №03 тоот тогтоолоор үүсгэн байгуулагч хувьцаа эзэмшигчид нь тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй бөгөөд шинээр гаргаж буй хувьцааг 100% олон нийтэд санал болгоно.

Нийт хувьцааны 16,67% буюу 7,700,000 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаагаар дамжуулан олон нийтэд санал болгох ба 83,33%-ийг "Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам"-ын 4.29.1-д заасны дагуу компанийн үүсгэн байгуулагчид дараах байдлаар хөрвүүлэн эзэмшинэ.

***Хаалттай компанийн хувь нийлүүлэгчдийн хөрвүүлэн эзэмших хувьцааны ширхэг:***

| № | Хувьцаа эзэмшигч | Тоо ширхэг | Эзэмших хувь /%/ |
|---|---|---|---|
| 1 | "Э-Транс" ХХК | 23,100,000 | 50.00% |
| 2 | Би Ди Пи И Эф ХХК | 1,500,000 | 3.25% |
| 3 | Х.Батхишиг | 700,000 | 1.52% |
| 4 | Монголиан транспортэйшн холдинг ХХК | 13,200,000 | 28.57% |
| | ***Нийт хөрвүүлэн эзэмших хувь*** | ***38,500,000*** | ***83.33%*** |
| 5 | Олон нийтэд санал болгох | 7,700,000 | 16.67% |
| | ***Нийт*** | ***46,200,000*** | ***100.00%*** |

*Хүснэгт 14 Хувь нийлүүлэгчдийн хөрвүүлэн эзэмших хувьцааны ширхэг*

Хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар олон нийтэд санал болгоно. Компанийн ТУЗ-ийн 2011/04/19 өдрийн №04 тоот тогтоолоор олон нийтэд санал болгох хувьцааны доод үнийг 120 төгрөгөөр тогтоосон.

СЗХ
2012 он 01 сар 18. өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 2.5. ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛИЙН АРГААР АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТУХАЙ

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь Санхүүгийн зохицуулах хорооны "Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам"-ын 4.6.3, 4.12-4.20-т болон, Монголын хөрөнгийн биржийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 5-р зүйлд заасны дагуу явагдана.

### *Үнэт цаасыг олон нийтэд санал болгох хугацаа*

1. Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь МХБ болон ҮЦТТХТ-тэй тохиролцон захиалгын бүртгэл эхлэх, дуусах хугацааг тогтооно.

2. Захиалгын бүртгэл эхлэхээс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө брокер дилерийн компаниудад хүргүүлж, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 10-аас доошгүй удаа зарлана.

3. Үнэт цаасыг нийтэд 6-аас доошгүй хоног танилцуулсны дараа анхдагч зах зээлийн захиалгыг авч эхлэх бөгөөд 1 сараас илүүгүй хугацаанд авна.

### *Үнэт цаасыг олон нийтэд санал болгох, байршуулах үнэ*

1. Үнэт цаасыг олон нийтэд санал болгох доод үнийг 120 төгрөгөөр тогтоосон.

2. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах үнийг андеррайтер, үнэт цаас гаргагч нар хамтран тогтооно. Уг үнийг тогтоохдоо тухайн үнэт цаасыг худалдан авахаар ирүүлсэн нийт захиалгын жигнэсэн дундаж үнэ, үнэт цаасны борлуулалтаас олохоор төлөвлөсөн хөрөнгийг бүрэн бүрдүүлэх боломжит үнэ, аль болох олон этгээдийн захиалгыг биелүүлэх боломжит үнэ зэргийг харгалзана.

### *Үнэт цаас худалдан авах захиалга*

1. Захиалгыг брокер дилерын компаниар дамжуулан худалдан авах бөгөөд хүлээн авсан захиалгыг өдөр бүр МХБ-ээс тогтоосон цагт МХБ-ийн үнэт цаасны ердийн арилжааны захиалгыг арилжааны программд бүртгэн авдагтай нэгэн адилаар бүртгэнэ.

2. Үнэт цаас худалдан авагч нь захиалгыг бүртгэх хугацаанд тодорхой үнээр, тодорхой тооны үнэт цаас худалдан авах захиалга өгнө.

3. Мөн тодорхой үнэ, тоо заалгүй худалдан авах нийт үнийг дүнг заасан захиалгыг өгч болно. Уг захиалгыг биелүүлэхдээ анхдагч зах зээлд байршуулахаар тогтсон үнээр нийт үнийн дүнд тохирсон үнэт цаасыг байршуулна.

4. Бүртгэгдсэн захиалгыг баталгаажуулах зорилгоор захиалга өгөхдөө барьцаа хөрөнгийг /Захиалгын үнийн дүнгийн 30-аас доошгүй хувиар/ ҮЦТТХТ дахь дансандаа байршуулах бөгөөд захиалга хаахаас 24 цагийн өмнө захиалга хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг бүрэн байршуулсан байна.

5. Захиалсан үнэт цаасны төлбөрт зориулсан барьцаа хөрөнгийг арилжаа хийгдэх хүртэл тусгаарлах арга хэмжээ авна.

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 2.5 ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛИЙН АРГААР АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТУХАЙ

6. Захиалгын маягтыг бүрэн бөглөж, худалдан авах үнэт цаасны төлбөрийг ҮЦТТТХТ-ийн дансанд байршуулсан бөгөөд МХБ-ийн бүртгэлд орсон захиалгыг хүчин төгөлдөр гэж тооцно.

### *Үнэт цаасны хуваарилалт*

1. Үнэт цаасны захиалга авах хугацаа дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан үнэт цаасны худалдах үнийг тогтоож биелэх боломжтой биелэх боломжтой захиалга тус бүрээр үнэт цаасны хуваарилалтыг хийнэ. Энэ үед захиалга өгсөн этгээдийн дансанд үнэт цаасыг байршуулахгүй бөгөөд урьдчилсан байдлаар тухайн захиалагчид ногдох хувьцааны тоо ширхэгийг тогтооно.

2. Үнийг тогтоосны дараа тогтоосон үнэ болон түүнээс дээгүүр үнээр захиалга өгсөн этгээдэд цаг хугацааны дарааллаас үл хамаарч[1] захиалсан хувьцааны тоонд хувь тэнцүүлэн хуваарилана.

3. Захиалгын үнэ давхардсан тохиолдолд цаг хугацааны дэс дараалалыг харгалзан захиалга биелэгдэнэ.

4. Хуваарилагдаагүй үлдсэн хувьцааг зарласан боловч эргэлтэнд гаргаагүй хувьцаа гэж тооцон бүртгэнэ.

5. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа дуусах хүртэл хугацаанд борлуулалтын орлогыг үнэт цаас гаргагчид шилжүүлэхгүй төвлөрсөн хадгаламжинд хадгална.

6. Үнэт цаас гаргагчаас үнэт цаасыг олон нийтэд амжилттай санал болгон шаардлагатай санхүүжилтийг босгосны дараагаар МХБ-ийн журмын дагуу үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх ба энэ үед хувьцаа худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа зарж борлуулах эрх нээлттэй болно.

## 2.6. ХУВЬЦААНЫ ЭРГЭЛТИЙГ ТҮГЖИХ БУЮУ ХУВЬЦАА ТУСГААРЛАХ /LOCK UP/

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2012/01/18-ны өдрийн №26 тоот тогтоолын дагуу компанийн одоогийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааг үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай дууссан гэж үзсэн өдрөөс эхлэн 18 сарын хугацаанд тусгаарлана.

[1] Энэхүү хугацааг захиалга авахаар нийтэд зарласан хугацааны дотор ирсэн захиалгын цаг хугацааны цаг хугацааны дарааллаас үл хамаарахаар ойлгоно.



3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

| | | 1 дахь долоо хоног | | | | | 2 дахь долоо хоног | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 1 | 2 | 3 | 4 | 5 | |
| **СЗХ-ны тогтоол, МХБ-ын бүртгэл** | СЗХ-ны тогтоол гарснаар нийтэд санал болгох нөхцөл бүрдэх | | | | | | | | | | | |
| **Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах** | Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, брокерын компаниудын цахим хуудас, и-мэйл зэргээр танилцуулга хийх | | | | | | | | | | | |
| **Захиалга авах, хаах** | | | | | | | | БДК-иудаар дамжуулан ажлын 2 өдрийн хугацаанд захиалга бүртгэх ба захиалгыг сүүлийн ажлын өдрийн арилжааны цаг дуусахад хаана. | | | | |
| **Захиалга дүгнэх, үнэ тогтоох** | | | | | | | | | Нийт захиалгыг хүлээн авч, анхдагч зах зээлд худалдах, үнийг зах зээлийн эрэлтэнд тулгуурлан тогтооно. | | | |
| **Арилжаалах зөвшөөрөл авах** | | | | | | | | | | Анхдагч зах зээлийн арилжаа хийх зөвшөөрөл Хорооноос авна. | | |
| **Анхдагч зах зээлийн арилжаа** | | | | | | | | | | Анхдагч зах зээлийн ажиллагааг зохион байгуулна. | | |
| **Тайлан гаргаж СЗХ-нд өгөх** | | | | | | | | | | | Үнэт цаасны арилжааны тайланг СЗХ-нд өгнө. | |
| **Хоёрдогч зах зээлийн арилжаа** | | | | | | | | | | | СЗХ-ны зөвшөөрлөөр хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. | |
| **ХЭХ болох** | | | | | | | | | | ХЭХ хуралдуулах тухай ТУЗ-ын шийдвэр гарах ба ХЭХ зарлах тухай мэдэгдлийг СЗХ, МХБ-д хүргэнэ. | | Бүртгэх өдрөөс хойш 45-аас доошгүй хоногийн дараа хуралдана |

*Хүснэгт 15 Анхдагч зах зээлд байршуулах график*

СЭХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## Үнэт цаасыг хэн худалдан авах вэ?

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд ҮЦТТТХТ-д данс нээлгэсэн Монгол улсын болон гадаадын аж ахуй нэгж байгууллага, хувь хүн оролцох эрхтэй.

## Үнэт цаасыг хэрхэн худалдан авах вэ?

1. Үнэт цаасны арилжаа нь МХБ-ийн үнэт цаасны арилжаагаар явагдах бөгөөд хөрөнгө оруулагчид нь үнэт цаасны арилжаанд оролцохын тулд аль нэг брокерийн компанид үнэт цаасны данс нээлгэсэн[2] байна.
2. Хөрөнгө оруулагч нь арилжаанд оролцохдоо үнэт цаасны худалдан авах үнийн дүн болон шимтгэлд төлөх төлбөрийн нийлбэр дүнтэй тэнцэх мөнгөн хөрөнгийг үнэт цаасны төлбөр тооцооны дансандаа байршуулсан байх шаардлагатай

## Хувьцаа худалдан авах мөнгийг үнэт цаасны дансанд байршуулах

Хөрөнгө оруулагч нь худалдан авах хувьцааны үнийн дүнтэй тохирсон болон арилжааны шимтгэлийн нийлбэр дүнгээс багагүй хэмжээний мөнгөн хөрөнгийг дансандаа байршуулсан байна.

"ҮЦТТТХТ" ХХК дахь үнэт цаасны дансандаа мөнгийг дотоодын аль ч арилжааны банкнаас шилжүүлэх боломжтой бөгөөд шилжүүлэг хийхдээ тухайн брокерын компанийн код болон үнэт цаасны дансны дугаараас бүрдсэн 12 оронтой тоог ашиглана. Банкны шилжүүлгээр мөнгө байршуулах нь хөрөнгө оруулагчдад аль ч улсаас мөнгө шилжүүлэн хийх боломжийг олгож байгаа юм.

Та банкны маягтын төлбөрийн зориулалт гэсэн хэсэг дээр орон нутгийн хувьцааны мөнгө гэсэн утгыг бичнэ. Жишээг доор харуулав:

ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ/Deposit slip/ Валют/Currency:/______/

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Огноо/Date: | Салбар/Branch | Журнал №/Journal N | | | |
| 5/10/2010 | ҮЦТТТХТ | | | | |
| Дансны дугаар/Account Number: | | Валютын код/Currenc Code: | | | |
| 000700066666 | | | | | |
| Данс эзэмшигчийн нэр/Account holder: | | Гүйвүүлгын код/Code | | | |
| Э.ТАМИР | | | | | |
| Гүйлгээний код/Transaction Code: | | Гүйлгээний дүн/Transaction Amount: | 100 | | |
| | | 50,000 | 500 | | |
| Гүйлгээний утга/Description: | | | 1000 | | |
| Хувьцааны мөнгө | | | 5000 | | |
| Гүйлгээний хураамж/Transaction Fee: | | Тэмдэглэл/Note: | | | |
| [ ]Данснаас /from account/ [ ]Бэлнээр /Cash/ | | | | | |
| | | | Бүгд /Total | | |

Э.Тамирын үнэт цаасны дансны дугаар "07-66666" бол 07 гэдэг нь брокерын компанийн дугаар, 66666 нь үнэт цаасны дансны дугаар юм. Орлогын мэдүүлэгт дансны дугаараа бичихдээ 000700066666 гэж 12 оронтой болгон бичнэ.

Хувьцаа худалдан авах тохиолдолд **ХУВЬЦААНЫ МӨНГӨ** гэж бичнэ

[2] Үнэт цаасны данс нээлгэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг брокерийн компаниудаас авна уу.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## Татвар, шимтгэл

Арилжааны шимтгэл

Хөрөнгө оруулагч үнэт цаасны арилжаанд ороход нийт гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар шимтгэл төлөх ба тус шимтгэл нь Та өөрийн брокерийн компанид данс нээлгэхдээ тогтоосон хувь байна.

Ногдол ашгийн татвар

"Хувь хүний орлогын албан татварын тухай" хуулийн 30.2 дугаар зүйл "энэ хуулийн 13.1.3, 13.1.4-т заасан орлогод 2013/01/01-ний өдрөөс эхлэн албан татвар ногдуулна" гэж заасан ба 13.1.3 "ногдол ашгийн орлого" ба 13.1.4 "хүүгийн орлого" гэж тодорхойлжээ.

*Иймд иргэн, хувь хүн ногдол ашгийн орлогод 2013 он хүртэл татвар төлөхгүй.*

"Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн 16.3 "Дараахь орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдуулах тухайн орлого тус бүрийн нийт дүнгээр тооцно", 16.3.1 "ногдол ашгийн орлого", 17.2 "Албан татвар төлөгчийн дараахь орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулна", 17.2.1 "ногдол ашгийн орлогод 10 хувиар" гэж заагдсан.

*Иймд ногдол ашгийн орлого олсон байгууллага нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар ногдол ашгийн орлогоосоо 10 хувиар татвар ногдуулж төлнө.*

Борлуулалтын орлогоос олсон ашгаас татвар төлөх:

Хувьцаа борлуулсан тохиолдолд албан татвар төлөх орлогыг тодорхойлохдоо худалдсан үнээс худалдан авсан үнийг хасч худалдах болон худалдан авахад төлсөн шимтгэлийг хасч тодорхойлно.

*Хувь хүн аж ахуйн нэгж нь дээрх дүнгээс 10 хувиар тооцон орлогын албан татвар төлнө.*

## Валютын ханш

МХБ-ийн арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр (MNT) хийгдэнэ. Ханшийг тухайн өдрийн зах зээлийн ханшаар тооцно.

Арилжааны банкууд төгрөгтэй харьцах гадаад валютын ханшийг өдөр бүр шинэчлэн тогтоож олон нийтэд зарладаг. Монгол Улсын томоохон арилжааны банкуудын ханшийн мэдээлэл авах цахим хаягууд:

Голомт банк: **www.golomtbank.com**

Хаан банк: **www.khanbank.com**

Төрийн банк: **www.statebank.mn**

Худалдаа хөгжлийн банк: **www.tdbm.mn**

Хадгаламж банк: **www.savingsbank.mn**

5309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ

УЛААНБААТАР ХОТ
МХБ-ийн гишүүн Андеррайтер Брокер, дилерийн "БИДСЕН" ХК

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 2.7. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗАМААР ХУРИМТЛУУЛАХ ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙН ТООЦОО

Үнэт цаас гаргагч компани нь нийт 7,700,000 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалж санхүүжилт татан төвлөрүүлнэ.

| | |
|---|---|
| *Үнэт цаас гаргагч компанийн нийт хувьцаа* | *46,200,000* |
| *Олон нийтэд санал болгох хувь* | *16.67%* |
| ***Санал болгох хувьцааны ширхэг*** | ***7,700,000*** |
| Хувьцааны нэрлэсэн үнэ | 100 |
| Эзэмшигчдийн өмчийн нэмэгдэх дүн | 770,000,000 |
| ***Нийтэд санал болгох доод үнэ*** | ***120*** |
| ***Татан төвлөрүүлэх дүн*** | ***924,000,000*** |

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тооцоонд 7,700,000 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгох доод үнэ 120 төгрөгөөр илэрхийлэн тооцсон.

### *Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт*

Үнэт цаас гаргагч компанийн ирэх 5 жилд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлуудын 49%-ийг үнэт цаас гарган олон нийтэд санал болгон санхүүжилт татан төвлөрүүлэх замаар шийдвэрлэх бол 51%-ийг үйл ажиллагааныхаа ашгаар санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа. Үнэт цаасыг олон нийтэд санал болгох доод үнийг 120 төгрөгөөр тогтсон ба олон нийтэд захиалгын бүртгэлийн аргаар байршуулах бөгөөд 120 төгрөгөөс дээш үнээр борлуулсан тохиолдолд нэмэгдэл татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараагийн жилүүдийн үйл ажиллагааны ашгаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг урьдчилан хийж гүйцэтгэнэ.







*График 5 Санхүүжилтийн хэлбэр, IPO зарцуулалт*

3309665 ГСТ1645
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХХК
ДОРНОГОВЬ АЙМАГ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2012 он 01 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

| № | ХИЙГДЭХ АЖЛУУД | 2012 | | 2013 | 2014 | 2015 | НИЙТ ЗАРДАЛ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ***Санхүүжих хэлбэр*** | ***IPO*** | ***Үйл ажиллагааны ашгаас*** | ***Үйл ажиллагааны ашгаас*** | ***Үйл ажиллагааны ашгаас*** | ***Үйл ажиллагааны ашгаас*** | ***Нийт дүн*** |
| 1 | Нэг цэгийн үйлчилгээний төв | 434,050,000 | 115,950,000 | 62,000,000 | | | 612,000,000 |
| 2 | Автокран 50тн | | | | | 365,000,000 | 365,000,000 |
| 3 | Автопогрузчик 3тн* | 87,500,000 | | | | | 87,500,000 |
| 4 | Бoодлын ачаа шилжүүлэн ачих туузан дамжуурга. | 156,250,000 | | | | | 156,250,000 |
| 5 | Вагоноос авто машинд нунтаг ачааг шилжүүлэн ачих туузан дамжуурга | 200,000,000 | | | | | 200,000,000 |
| 6 | Хүнд даацын машин явахад зориулсан бетондсон талбай /10,000 кв.м/ | | | 150,000,000 | 200,000,000 | | 350,000,000 |
| 7 | Хөрөнгө оруулалт татахтай холбогдсон зардал | 46,200,000 | | | | | 46,200,000 |
| | ***НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ*** | ***924,000,000*** | ***115,950,000*** | ***212,000,000*** | ***200,000,000*** | ***365,000,000*** | ***1,816,950,000*** |

***-оор тэмдэглэсэн тэмдэглэсэн тоног төхөөрөмжийг Э-Транс ХХК-аас авсан зээл болон үйл ажиллагааны ашгаас санхүүжүүлэн худалдан авсан.***

